

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 07 дугаар сарын 02-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-41

-
- | | |
|---|-------|
| 1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ | 6-17 |
| 2.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/ | 17-41 |

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны 07 дугаар сарын
02-ны өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Д.Батбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 12 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 02 минутад Төрийн ордны “Жанжин Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Батлут, Г.Дамдинням, З.Мэндсайхан.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Боловсролын сайд П.Наранбаяр, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрэм, Гэр бүл, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, мөн зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, Н.Ууганбаатар, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын нарийн бичгийн дарга Ч.Цасчихэр, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Хүний эрхийн Үндэсний комиссын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн

дарга Д.Ганхуяг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Уртнасан, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэг, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, мөн газрын Татварын орлогын газрын дарга С.Баярмаа, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татварын хураалт, удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, мөн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Төлбөр тооцооны хэлтсийн дарга Н.Саруул, Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Ч.Тавинжил, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт С.Төрмөнх, Шадар сайдын ахлах зөвлөх Х.Оюунцэцэг нар байлцав.

Хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаар Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Хуулийн төслүүдийн талаарх танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Да.Цогтбаатар нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм нар хариулж, тайлбар хийв.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Батлан

хамгаалахын сайд Д.Батлут, Боловсролын сайд П.Наранбаяр, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрэм, Гэр бүл, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, мөн зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, Н.Ууганбаатар, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын нарийн бичгийн дарга Ч.Цасчихэр, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Хүний эрхийн Үндэсний комиссын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Уртнасан, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэг, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, мөн газрын Татварын орлогын газрын дарга С.Баярмаа, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татварын хураалт, удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, мөн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Төлбөр тооцооны хэлтсийн дарга Н.Саруул, Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Ч.Тавинжил, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт С.Төрмөнх, Шадар сайдын ахлах зөвлөх Х.Оюунцэцэг нар байлцав.

Дэд хорооны дарга Д.Батбаяр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4.2 дахь хэсэгт заасны дагуу Байнгын

хороодоос санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд ирүүлснийг Дэд хорооны гишүүдэд хүргүүлсэн талаар танилцуулав.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, тогтоолын төсөлд хийсэн аудитын талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, Ж.Батжаргал, Да.Цогтбаатар, Д.Пүрэвдаваа, Б.Бейсен, Д.Батбаяр нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн, Дэд хорооны дарга Д.Батбаяр үг хэлэв.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Дэд хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 14 минут үргэлжилж, 12 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 12 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН
ДЭД ХОРООНЫ ДАРГА

Д.БАТБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Лхагва гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхимд 10 цаг 02 минут

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Батбаяр: Дэд хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая аа. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, дэд хорооны ирц 58.3 хувьтай бүрдсэн тул Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Засгийн газрын 2025 оны 6 сарын 25-ны 2 дахь хэлэлцүүлэг санал дүгнэлт.

2 дахь асуудал нь Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Хэлэлцэх асуудалтай байхгүй байгаа тул хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байхгүй байгаа тул хэлэлцэх асуудалдаа орёе.

Ажлын хэсэг байгаа тиймээ. Нэг. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя аа. Сангийн сайд Жавхлан орж ирнэ. Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Учрал орж ирнэ. Монгол Улсын Шадар сайд Тогмидын Доржханд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Лхагвын Мөнхбаатар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Батын Батбаатар, Батлан хамгаалахын сайд Дамбын Батлут чөлөө авсан байсан. Боловсролын сайд Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Гонгорын Дамдинням, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбаагийн Энхбаяр, Эрүүл мэндийн сайд Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Энхтайваны Бат-Амгалан, Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Чинбатын Ундрэм, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Тилеуханы Аубакир, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Энхбаярын Батшугар, Төрийн албаны зөвлөлийн дарга Лхагвын Цэдэвсүрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Нямсүрэнгийн Мөнгөнцэцэг. Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн, Санхүүгийн

зохицуулах хорооны дарга Түндэвийн Жамбаажамц, Үндэсний статистикийн хорооны дарга Батмөнхийн Батдаваа, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Содномцэрэнгийн Заяадэлгэр, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Батсуурийн Даваадалай байхгүй байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Батдэмбэрэлийн Эрдэнэтулга, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Жамсрандоржийн Дэлгэрсайхан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ланганы Отгонтуяа, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Нинжбатын Ууганбаатар, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Занданбазарын Цэдэнжав, Үндэсний аудитын газрын санхүү-нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Цэвэгсүрэнгийн Наранчимэг, Үндэсний аудитын газрын гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын дарга тэргүүлэх аудитор Дэлгэрийн Энхболд, Улсын ерөнхий прокурорын Хэрэг эрхлэх газрын дарга Сүрэнжавын Гансэлэм, Цагаатгах ажлыг удирдах зохион байгуулах комиссын нарийн бичгийн дарга Чүлтэмсүрэнгийн Цасчихэр, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга Загараагийн Баасанням, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Болдын Цэнгэл, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Идэшийн Батхүү, Хүний эрхийн үндэсний комиссын Тамгын газрын дарга Цээхээгийн Адъяахишиг, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Лхан-Аажавын Мөнхтүшиг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Нэргүйн Мягмар, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Дагвадоржийн Ганхуяг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Цэцэгмаагийн Уртнасан, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ханджавын Батжаргал, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Санжаадоржийн Оюунбилэг, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Пушагийн Алтан-Од, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Дагвадоржийн Очирбат, Хүний эрхийн үндэсний комиссын Тамгын газрын дарга энэ дуудсан, Гаалийн ерөнхий газрын дарга Рэгжийбуугийн Отгонжаргал, Татварын ерөнхий газрын дарга Чойгүнсэнгийн Чимидсүрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Солонгын Тулга, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгийн оруулалтын газрын дарга Жамъяншаравын Дэлгэржаргал, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Бэлтрэгийн Цогбадрах, Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Чойжилсүрэнгийн Тавинжил байхгүй байна уу тиймээ. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Зоригоогийн Тулга, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Огнонгийн Хуягцогт, Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Нарангийн Мөнхсүх, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Лувсандоржийн Гантогтох, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Булганхүүгийн Ганзориг, Сангийн яамны Төрийн сангийн газрын төлбөр тооцооны хэлтсийн дарга Нямдаваагийн Саруул, Гаалийн ерөнхий газрын Татварын орлогын газрын дарга Сангидоржийн Баярмаа, Татварын ерөнхий газрын Татвар хураалт, удирдлага, арга зүйн газрын дарга Рэгзэнгийн Мягмаржав нар хүрэлцэн ирсэн байна аа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна аа. Сайд хажууд байна гэсэн дуудсан уу Ганбат дарга аа. За одоо хүлээж байгаарай. Сангийн сайдын микрофоныг нээе. Сангийн сайдын микрофоныг нээгээрэй. Манай ажлын албаныхан.

Б.Жавхлан: Их баярлалаа. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Дэлхий дахинд үүсээд буй сорилт бэрхшээлийн Монгол Улсын эдийн засаг, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, мөн Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.1.4 дэх заалтын дагуу Монгол Улсын 2025 онд төсвийн тодотголын төслийг боловсруулж, 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүллээ.

Эдийн засгийн сорилт хүндрэлийг даван туулахад төсвийн сахилга бат, үр ашигтай зарцуулалт онцгой чухал үүрэгтэй. Тиймээс хэмнэлтийн тодотголд бүх шатны төрийн байгууллагуудын тэвчиж болох зардлыг хэмнэсэн бөгөөд дараах зарчмыг баримталлаа. 1 дүгээрт оновчтой бүтэцтэй, цомхон, чадварлаг төрийн албыг бий болгоно. Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлтийн хүрээнд Боомтын сэргэлтийн үндэсний хороо, Хяналт, үнэлгээний үндэсний хороо. 20 минут хот, үндэсний хороодыг татан буулгаж, холбогдох чиг үүргийг шилжүүлсэн бөгөөд Хилийн боомтын захиргааг Сангийн сайдын багц руу Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын багц руу, 20 минутын хот хөгжлийн төвийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багц руу тус тус шилжүүллээ.

Тус арга хэмжээний хүрээнд 48 орон тоо, 8.4 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардлыг хэмнэнэ ээ. Мөн салбарын хуулиар тусгайлан зохицуулаагүй чиг үүргийн давхардалтай хороо, зөвлөл, комисс болон тэдгээрийн ажлын албыг татан буулгах бодлогын хүрээнд Монгол Улсын олон улс дахь Сурталчилгаа мэдээллийн үндэсний хороо, Үндэсний баялгийн сан, Орон сууцжуулалтын үндэсний хороо, Хархорум хотын бүтээн байгуулалтын үндэсний хороо, Аж үйлдвэржилтийн үндэсний хороо, Алсын хараа 2050, салбар дундын уялдааг хангах Үндэсний хороо, Эрчим хүчний реформын уялдааг хангах Үндэсний хороо, Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хороо, Эдийн засгийн бодлогын зөвлөлийн ажлын алба, Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөл, Сансрын бодлогын үндэсний зөвлөлийг тус тус татан буулгаж, 40 орон тоо 11.2 тэрбум төгрөгийг хэмнэхээр тус тус тооцлоо.

Төрийн албаны бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, чиг үүргийн давхардлыг бууруулж, чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх зорилтын хүрээнд багш, эмчээс бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулахаар тооцож 14.4 мянган орон тоо, цалин хөлсний зардал 261 тэрбум төгрөгийг хэмнэхээр тооцлоо.

2 дугаарт, Төрийн ажил, үйлчилгээг цахимд шилжүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх, инновацыг салбар бүрийн онцлогт нийцүүлэн нэвтрүүлэх замаар иргэдэд хүрэх төрийн үйлчилгээний чанарыг бууруулалгүй бүх шатны төрийн байгууллагуудын тэвчиж болох зардлыг хэмнэнэ ээ. Энэ хүрээнд бүх шатны төрийн байгууллагуудын зайлшгүй нэн тэргүүний шаардлагатайгаас бусад тэвчиж болох зардлыг хэмнэж, хэрэгжиж байгаа хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хэмнэлтийн

горимоор үргэлжлүүлэх, харин хэрэгжиж эхлээгүй хөтөлбөр арга хэмжээг бүрэн хэмнэхээр тооцлоо. Үүнд:

1.Засгийн газрын шийдвэрээр төрөөс иргэн хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний төлбөр хураамжийг 2025 оны төсвийн жилийг дуустал нэмэгдүүлэхийг хориглосонтой холбоотойгоор төсвийн төсөвт байгууллагуудын түлш халаалтын тарифыг нэмэгдүүлэхээр тооцож 2025 оны төсөвт тусгасан байсан халаалтын зардлыг хэмнэлтээр тооцож 121.9 тэрбум төгрөгөөр.

2.Төрийн тусгай байгууллагуудаас бусад бүх шатны төсвийн байгууллагуудын тээвэр шатахуун, дотоод албан томилолт, хичээл үйлдвэрлэлийн зардлыг хэмнэхээр тооцож 28.9 тэрбум төгрөгөөр.

3.Төрийн өндөр дээд айлчлалын болон гаднын өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг хэмнэхээр тооцож холбогдох зардлыг 4.5 тэрбум төгрөгөөр.

4.Бүх шатны төсвийн байгууллагын тавилга, эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх болон багаж техникийн зардлыг тэвчиж зардлыг 104.4 тэрбум төгрөгөөр.

5.Төсвөөс төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад олгодог татаасын зардлыг 76.8 тэрбум төгрөгөөр.

6.Байгууллагаас олгох нэг удаагийн болон бусад төрлийн тэтгэмж, урамшууллыг хэмнэж, зардлыг 30.2 тэрбум төгрөгөөр.

7.Бүх шатны төсвийн байгууллагуудын хэрэгжүүлдэг хөтөлбөр арга хэмжээний зардлыг хэмнэх хүрээнд 617.3 тэрбум төгрөгөөр тус тус хэмнэхээр тооцож, холбогдох зөрчлийг өөрчлөлтийг тодотголд тусгалаа.

Дээрх арга хэмжээний хүрээнд хэмнэлтийн тодотголоор төсвийн зардлыг 1 их наяд 508.4 тэрбум төгрөгөөр бууруулахаар тооцлоо. Үүн дээр Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу 2025 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор худалдан авах ажиллагааг бүрэн тусгах гэрээ байгуулаагүй төслүүдийн санхүүжилтийг хэмнэлтэд тооцох, зарцуулахгүй байх зохицуулалтын хүрээнд Засгийн газрын 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар батлагдсан төсвийн хэмнэлт тооцох тухай тогтоолд туссан 535.9 тэрбум төгрөг нэмж тооцвол нийт 2 их наяд 44.2 тэрбум төгрөгөөр зарлагаар буурахаар байна аа.

Уг тогтоолын хүрээнд Эрүүл мэндийн сайдын багцаас 69.9 тэрбум төгрөг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаас 57.7 тэрбум төгрөг, Хот байгуулалт, орон сууцжуулалтын сайдын багцаас 36.6 тэрбум төгрөг, Боловсролын сайдын багцаас 33.7 тэрбум төгрөг, Зам тээврийн сайдын багцаас 33.4 тэрбум төгрөг, Соёл спорт, аялал жуулчлалын сайдын багцаас 19.7 тэрбум төгрөг, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын багцаас 17.4 тэрбум төгрөг, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцаас 12.4 тэрбум төгрөг, бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарын багцаас 255.4 тэрбум төгрөг, нийт 535.9 тэрбум төгрөгийг төсвийн хэмнэлтэд тооцсон болно.

Нөгөөтээгүүр Монгол Улсын олон улсад хүлээсэн үүрэг болон эрчим хүчний найдвартай байдлыг хангах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд зайлшгүй

шаардлагатай дараах 3 зардлыг төсвийн тодотголд нэмж тусгасан болно. Үүнд Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын конвенцын Байнгын нарийн бичгийн дарга газар хооронд 2025 оны 2 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан Хэлэлцээрийн хүрээнд СОР 17 дугаар бага хурлыг 2026 оны 8 дугаар сард Монгол Улсад зохион байгуулахтай холбогдуулан хурлын бэлтгэл ажилд шаардагдах хөрөнгө оруулалт.

2.ДЦС 3 төрийн өмчийн ХК-ийн өндөр даралтын турбин цехийн барилга байгууламжид гэнэтийн аваар осол, гал гарч томоохон эрсдэл үүссэнтэй холбогдуулан гамшиг ослын хохирол, хор уршгийг бууруулах, өвлийн их ачаалалд дулаанжуулалтын тоноглолын бэлэн байдлыг хангах зайлшгүй шаардлагын хүрээнд гарах зардал болон дулааны станцууд эрчим хүчний компаниудын найдвартай ажиллагааг хангах. Эрчим хүчний шөнийн тарифын хөнгөлөлтийн хугацааг уртасгасантай холбогдох зардал.

3.Зуны үер ус, намрын тариалалт болон өвөлжилтийн бэлтгэл хангахтай холбогдуулан урьдчилан тооцож төлөвлөж тусгах боломжгүй цаг үеийн шинжтэй арга хэмжээг санхүүжүүлэх нөхцөл үүсэж болзошгүйг харгалзан үзэж Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг нэмэгдүүлэн тусгалаа.

Ийнхүү 2025 оны төсөвт тодотгол хийснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 3 их наяд 260 тэрбум төгрөгөөр, 3 их 30 их наяд 209.9 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг 1 их наяд 856 тэрбум төгрөгөөр бууруулж, 31 их наяд 575.1 тэрбум төгрөгт хүргэж, нэгдсэн түвшинд тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 365.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.5 хувийн алдагдалтай болж байна аа.

Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Д.Батбаяр: Сангийн сайдад баярлалаа. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаар Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна, 5 номерын микрофоныг нээе.

С.Магнайсүрэн: Зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хууль, Төрийн аудитын тухай хуульд заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 сарын 25-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хийж гүйцэтгэлээ.

1.Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн бодлоготой нийцэж байгаа. Төсвийн төсөлд Засгийн газрын өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2025 онд 44.5 хувьд хүрэх төсөөлөлтэй байхаар тооцоолон тусгасан нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2-т заасан төсөв санхүүгийн салбарын аюулгүй байдлыг хангасан зохистой харьцаанд байна.

2.Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасныг үндэслэн боловсруулж УИХ-д өргөн мэдүүлсэн байна. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 30 их наяд 209.9 тэрбум төгрөг, нийт зарлагын хэмжээг 30 их наяд 575.1 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 365.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.5 хувийн алдагдалтай, нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ 28 их наяд 401.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 31.6 хувь, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1 их наяд 808.2 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувийн ашигтай байхаар тооцжээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагуудыг хангасан байна.

3.2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын үзэл баримтлал, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн боловч дараах асуудлыг анхаарах нь зүйтэй байна аа. Үүнд:

Нэг.Уул уурхайн салбарын орлого гадаад зах зээлийн нөхцөл байдлаас хамаарч тодорхой бус эрсдэлтэй байгаа тул уул уурхайн бус орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн дайчлах, татварын хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах, хураалт үйлчилгээг сайжруулах.

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг төсөвт өөрчлөлт оруулах бүрд өөрчилж байгаа нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байгааг анхаарах.

Гурав.Төсвийн урсгал зарлагыг хумьж зарим хэрэгжиж эхлээгүй хөтөлбөр үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөсөн нь төсвийн зарлагын ДНБ-д эзлэх харьцааг бууруулсан сайн талтай боловч зардлыг шууд хассан нь 2025 онд төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нөлөөлж болзошгүй байгааг анхаарч үзэх.

Дөрөвт нь төрийн үйлчилгээг илүү цомхон бүтцээр үзүүлэхийн тулд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх тогтолцооны өөрчлөлтийг бүрэн хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Тав.Төрийн албан хаагчдын тоог чиг үүргийн давхардал, ажлын байрны ачаалалд бүрэн шинжилгээ хийгээгүйгээр нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарын орон тоог жигд 9 хувиар бууруулахаар тооцсон нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж болзошгүй. Иймд төсвийн ерөнхийлөн захирагчдад өөрийн хариуцсан салбартаа чиг үүргийн шинжилгээ ажлын байрны ба бүтээмжийн үнэлгээ хийсний үндсэн дээр

ажлын ачааллыг оновчтой хуваарилах зорилгоор харьяа байгууллагуудынхаа орон тоонд зохицуулалт хийх тэр боломжийг олгох асуудлыг судалж үзэх.

Зургаа.Төсвийн тодотголтой хамт УИХ-ын тогтоолын төсөлд 2025, 2026 оны төсвийн жилд өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх. Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаалын орон тоо бий болохгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулах зэргээр цалин хөлсний зардлыг хэмнэх тухай заасан. Энэ нь чиг үүргийн судалгаа хийсний үндсэн дээр ажлын ачааллыг нягтруулж, орон тоогоо зорилтот түвшин хүртэл нэгэнт бууруулсан байгууллагуудад сул орон тоондоо нөхөн томилгоо хийхгүй байх нь тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байгааг анхаарч үзэх.

Долоо.Төсвийн ерөнхийлөн захирагч нар харьяа сул орон тооноос бусад цомхотголд орж буй албан хаагчдад төрийн албаны тухай хуульд заасны дагуу ажлаас чөлөөлөгдсөний нэг удаагийн тэтгэмжийн зардал шаардагдахаар байгааг энэ хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад хамтад нь шийдвэрлэх гарц шийдлийг олох.

Дээрх саналуудаас гадна төсөвт тодотгол хийх нөхцөл үүссэн тохиолдолд төрийн аудитын байгууллагаас аудитын үйл ажиллагааны үе шатны стандартын дагуу хянаж, дүгнэлт гаргахад цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байх тохиолдлууд гарч байгааг анхааралдаа авч дүгнэлт гаргаж, Их Хуралд хүргүүлэх зохистой хугацааг Төсвийн тухай хуульд тусгаж өгөх шаардлагатай байна.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэснээ үүгээр танилцуулж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Батбаяр: Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудиторт баярлалаа. Одоо хуулийн төслүүдийн талаарх Сангийн сайдын танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Би ямар ч байсан асуулт асууна аа. Энэ тодотголтой холбоотойгоор Эрүүл мэндийн сайдын багцаасаа нийтдээ нэг 66 тэрбум төгрөг хасагдаж байгаа юм байна. Тэгэхээр эрүүл мэндийн салбар маань ерөөсөө байнга л санхүүжилтийн асуудалтай байдаг. Эмч нарын цалин ч бас бага байдаг. Тэгэхээр энэ хүртээмжгүй байдаг эм тариа нь байнга дутагдалтай байдаг. Өвчтөнүүд маань бүгдээрээ л өөрсдөө тариагаа хайгаад гадуур явж байдаг шүү дээ.

Тэгэхээр яг энэ эрүүл мэндийн үйлчилгээтэй болон эмч нарын байдалдаа ер нь яаж нөлөөлөх вэ? Энэ 66 тэрбумын асуудал. Энэ удаагийн тодотгол 1 дүгээр асуулт нь байна.

2 дугаарт нь боловсролын салбартай холбоотой. Боловсролын салбарт нэлээн их хэмжээний сургууль, цэцэрлэгүүд баригдаж байгаа. Үүнтэй зэрэгцээд үүнийг дагаад ажлын байрууд бас их бий болж байгаа. Тэгээд бид нар одоо энэ удаагийн тодотгол дээр бас энэ урсгал зардлаас нэлээн багасгана гэж орж ирж байгаа учраас шинээр бий болж байгаа ажлын байрууд болон урсгал зардлын харилцааг ер нь яаж хангах вэ? Энэ тодотгол маань энэ дээр яаж нөлөөлөх вэ? Ер нь яваа яваандаа энэ ажлын байрны ихсэл сургууль хөрөнгийн зардал нь улам

ихэснэ, цалингийн зардал маань бүр ихэснэ. Тэгэхээр энэ дээр ямар бодлого баримтлах вэ гэсэн ийм 2 асуулт байна аа.

Асуултад Сангийн сайд хариулна.

Б.Жавхлан: Дэд хорооны даргын асуултад хариулъя. Маш харамсалтай зүйл болж байгаа. Тодотголтой тодотголгүй 5 сарын 31-ээр төрийн хэмнэлтийн хуулийн дагуу нийтдээ 535 тэрбум төгрөгийн төсөл хөтөлбөрүүд одоо хэмнэлтэд тооцогдож байгаа. Энэ бол тодотголын дүн биш шүү. Тийм. Энийг маш сайн ялгаж хэдүүлээ яримаар байгаа юм. Тодотголоор 5 сарын 31-ээр гэрээ нь хийгдээгүй төсөл хөтөлбөрүүдийг хассан зүйл ерөөсөө огт байхгүй. За 5 сарын 31-ээр төрийн хэмнэлтийн хуулиар тодотголоос өмнө худалдан авах ажиллагаа нь хийгдээгүй ийм ажлууд бүгд одоо хэмнэлтэд тооцогдож байгаа. Цаашдаа энэ хуулийг болбол маш сайн бариад явна. Энд байгаа төсвийн ерөнхийлөн захирагч нар энийгээ маш сайн анхаарах ёстой шүү. Энэ бол яг төсвийн сахилга бат, дээрээс нь яг намар бас түрүүн Их Хурал дээр төсөв хэлэлцэж байх үед бэлтгэл ажил нь хангагдаагүй, зураг төсөв нь дутуу ийм зүйлүүдийг одоо хуульд оруулснаас болж тэр нь тэгээд шууд тендер зарлагдах боломжгүй ингэж хугацаа алдсаар байгаад ингээд 5 сарын 31 хүрчхэж байгаа юм.

Тийм учраас энийг одоо төсвийн шууд захирагчийн шатнаас эхлээд төсөв төлөвлөх Засгийн газрын түвшинд төсөв батлах, Их Хурлын түвшинд төсвийг одоо гүйцэтгэлээр хангах үүрэг бүхий Засгийн газрын түвшинд шат шатандаа энийг хойшдоо маш сайн анхаарах ёстой. Энэ хүрээнд Эрүүл мэндийн сайдын багц дээр байсан одоо 60 тэрбум төгрөг, мөн одоо дамжиж ирсэн 9 тэрбум төгрөг нийтдээ 69 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагаа нь одоо 5 сарын 31-нээр хийж амжаагүй маш олон одоо боломжтой байсан ийм тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтууд хэмнэлтэд тооцогдсон.

Ингэснээр энэ салбарын хөгжлийн зорилтот түвшин одоо тэр хэмжээгээр буурна аа гэсэн үг. Тэр хэмжээгээр дараа дараагийн төсвүүд дээр мөн ачаалал ирнэ ээ гэсэн үг. Уг нь энэ жилдээ арайхийж ингээд намаржингаа юу боллоо. Ингээд одоо төсөвт арайхийж орсон зүйлүүд маань гүйцэтгэл нь гарчихсан бол одоо маш их хэрэгтэй байсан. Гэсэн хэдий ч одоо бид хуулиа бариад ингээд хэмнэлтэд орсон.

Тийм учраас одоо энэ бол төсвийн ерөнхийлөн захирагч нарын сахилга бат, цаг хугацаандаа хийх ёстой ажлууд гээд маш чухал ийм зүйлүүд дараа дараагийн төсвийн жилүүд дээр онцгой анхаарах ёстой. Тэгээд төсвийн энэ зарлагын хяналтын дэд хороо. Тийм учраас энэ дээр бол энийг одоо зайлшгүй ярих ёстой ийм зүйл ээ гэж ингэж бодож байна тийм. Боловсролын яамны талаар Төрийн нарийн бичгийн дарга нь байна уу?

Д.Батбаяр: Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга. Ажлын хэсгийн та 9 номерын микрофон дээрээс хариулчих уу? За 9 номерын микрофоныг нээе.

Х.Батжаргал: Боловсролын яам Батжаргал. Гишүүний асуултад нэмж хариулъя. Шинээр баригдаж байгаа сургууль, цэцэрлэгийн ашиглалтад орсны дараах урсгал зардал болон түүнтэй холбогдох зардлууд бол ер нь хувьсах зардлаараа явдаг. Нэг хүүхдэд ноогдох хувьсах зардлын тоо хэмжээгээр. Тэгэхээр хүүхдийн нэг хүүхдэд ноогдож байгаа тоо хэмжээ бол өөрчлөгдөхгүй. Тогтмол зардлаараа ингээд тавигдаад явж байгаа учраас ямар нэгэн өөрчлөлт, хасалт

хөндөлт бол энд бол явагдахгүй. Хүүхдийн тоондоо хуваарилагдаад нэг хүүхдэд ноогдох 1 сая 200 мянган төгрөгийн энэ зардал бол тогтмол байж байгаа учраас хүүхдийн тоогоороо үржигдээд шинэ хөрөнгө оруулалт, шинээр ашиглалтад орж байгаа сургуулиудад бол зардал нь бол тавигдаад явж байгаа. Энэ бол ямар нэгэн хөнгөлөлт хасагдалт бол өртөхгүй байгаа гэсэн үг.

Д.Батбаяр: Сангийн сайдын хэлж байгаатай санал нэг байгаад байгаа юмаа. Бид нар чинь барилгын сезон бол маш бага. 4 сараас эхэлдэг 10 сар хүртэл явдаг учраас ажил маш эрт эхэлж байх ёстой. Аль хэдийн гэрээ нь хийгдсэн байх ёстой хавар, эрт хийгдсэн байх ёстой. Тендер нь шалгаруулчихсан байх ёстой. Тэгээд 5 сарын 31 хүртэл ажил хийж чадахгүй байгаа болбол тэгээд эргээд татагддаг. Энэ хэмнэлтийн хууль энэ болбол маш зөв хууль гэж харж байгаа. Тэгээд Сангийн сайдтай болбол санал нэг байгаад байгаа. Эртхэн ажлаа амжуулдаг байх ёстой, ажил эрт эхэлдэг байх ёстой.

Тэгэхээр энэ зарчмаараа ямар ч байсан 500 хэд билээ. 535 тэрбум төгрөг эргэж татагдсан тэгээд дараа жилийн төсвийг ярих үед бас ажлууд ороод ирэх байх. Мэдээж улсын ажил бас унаж болохгүй учраас илүү хариуцлагатай байх шаардлагатай болж таарч байна аа. Боловсролын яамны хувьд гэх юм болбол одоо та хэд маань яг энэ хувийн хэвшил танай салбарт бол энэ хувийн хэвшлийн оролцоо маш их байгаад байгаа шүү дээ. Хувийн сургуулиуд маш их байгаа. Төрийн энэ боловсролын энэ ажлаас их хуваалцаж явж байгаа. Тэгэхээр энэ хувийн хэвшлийн сургуулиудаа, цэцэрлэгүүдээ дэмжих бодлого маань ер нь өөрчлөгдөх юм уу, энэ чигээрээ явах юм уу гээд нэг асуучихъя аа.

Түрүүний асуулт дээр бас тодруулаад асуухад яг энэ шинээр бий болж байгаа энэ ажлын байруудаа, шинээр бий болж байгаа сургуулиудынхаа хөрөнгийн зардал дээрээ ямар бодлого баримтлах вэ гэдэг дээрээ та ахиад нэг маш товч бөгөөд тодорхой хариулчхаарай 2 асуулт байгаа шүү. Ажлын хэсгийн 9 номерын микрофоныг нээе.

Х.Батжаргал: Гишүүний асуултад нэмж хариулъя аа. Төсвийн тодотголтой холбоотойгоор төрийн болон хувийн өмчийн одоо аль ч хэлбэрийн сургууль цэцэрлэгийн хувьсах зардал, холбогдох зардлууд бол хасагдахааргүй байгаа. Зүгээр тодотголыг дагаж гарч байгаа УИХ-ын тогтоолын төсөл дээр бол энэ хувийн өмчийн сургуулийн хувийн өмчийн сургууль, цэцэрлэгийн зардал, хувьсах зардлыг бол одоо хязгаарлах байдлаар одоо зөвлөмж чиглэл болгосон ийм тогтоолын төсөл байгаа. Зүгээр тэрнээс яг энэ тогтоолын төсөл дээр бол хувийн өмчийн хувьсах зардлыг бол хязгаарласан зүйл бол байхгүй байгаа. Зүгээр цаашид барьж байгаа хөрөнгө оруулалтын бодлогын хувьд бол шинээр ашиглалтад орж байгаа сургууль...

Д.Батбаяр: 9 номерын нэг микрофон гүйцээж хариулъя.

Х.Батжаргал: Урсгал зардлын бас нэгээхэн хэсгийг эзэлдэг одоо нийтлэг үйлчилгээ үйлчилгээний одоо гол хэсэг сургууль, цэцэрлэгийн шинээр ашиглалтад орж байгаа сургууль, цэцэрлэгийн энэ зардлыг бас хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх талын арга хэмжээг бас төлөвлөөд Сангийн яамтайгаа бас зөвлөлдөөд явж байгаа. Өөрөөр хэлэх юм бол шинээр ашиглалтад ороход одоо хувьсах зардал дээр байдаг нийтлэг үйлчилгээний зардлаас гадна нэмээд бас төрийн үйлчилгээг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх энэ зардлыг бол бас нэмж тусгах замаар хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх байгаа. Мөн дээд боловсролын тухайд бас төр, хувийн хэвшлийн түншлэлийн замаар хөрөнгө оруулалтуудыг шийдвэрлэх тодорхой заалтуудыг бол

жилийн хөгжлийн төлөвлөгөөнд бас тусгасан байгаа. Тэгээд өөрөөр хэлэх юм бол төрийн ямар нэгэн дэмжлэг төсвийн зардлаар шийдэж чадахгүй байгаа энэ асуудлуудыг...

Д.Батбаяр: Ажлын хэсгийн 9 номерын микрофон гүйцээж хариулна.

Х.Батжаргал: Төр хувийн хэвшлийн түншлэлээр. Мөн Татварын тухай хуулийн одоо энэ нэмэлт өөрчлөлтөөр ААН-ийн албан татварын нэг хувийн тэнцэх хэмжээний энэ хөнгөлөлтийн зардлыг одоо хувийн хэвшлийн орж ирж байгаа энэ орлогыг бол хөрөнгө оруулалт, сургууль, цэцэрлэгийн барилга, төр хувийн өмчөөс үл хамаарсан энэ хөрөнгө оруулалтыг бол татварын энэ хөнгөлөлтөд тооцоолж оруулах замаар хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, хамтран шийдэх ийм бодлого баримталж байгаа.

Д.Батбаяр: Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ. Энэ төрийн албан хаагчийн тоог хасаж оруулж ирж байгаа гэж нэлээн яриад байгаа. Жишээлэхэд надад байгаа мэдээллээр болбол энэ Боловсролын яаманд харьяалагдаж байгаа байх аа. Энэ Монгол Японы эмнэлэг гэдэг газар дээр яг нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилчид сувилагч гэдэг ч юм уу эд нарыгаа нэмэх, эд нарын цалин хангамжийг нэмэхээсээ илүүтэйгээр захиргааны албан хаагчийг нэмээд тэнчээ ингээд нэг ийм үргүй зардал данхайсан бүтцийг бий болгоод байгаа. Яг энэ шигээ одоо бас энэ эрчим хүчний салбар дээр бол бас яг нэг ийм нарийн мэргэжлийн инженер, техникийн ажилчдаа нэмэхгүй, бас л нөгөө захиргааны албан хаагчийг нэмэгдүүлээд байгаа энэ нийтлэг дүр төрх чинь өөрөө төрийн албан хаагчийн орон тоо гээд яг мэргэжлийн ажлаа хийж байгаа төрийн албан хаагчдын нэр хүндэд бас сөргөөр нөлөөлөөд байгаа ийм тал байх шиг байгаа юм. Энэ дээр бас нэг Боловсролын яамнаас тайлбар мэдээлэл байвал сайн тийм.

Ер нь Боловсролын яаманд харьяалагдаж байгаа юм байна лээ. Тийм. Тэгээд дээрээс нь одоо энэ прокуроруудын тоон дээр бас нэг 600, 700 прокурор хүрч одоо ажлаа хийж байхад нь дахиад 114 прокурор хасахаар яг прокурорын ажил уначихгүйгээр жигд явж чадах эсэх дээр прокурорын байгууллагаас бас нэг төлөөлөөд л хариулж өгөөч. Ийм 2 асуулт байна.

Д.Батбаяр: 9 номерын микрофон Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга.

Х.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя аа. Батжаргал боловсролын яам. Монгол Японы АШУҮИС-ийн харьяанд Монгол, Японы эмнэлэг харьяалагдан үйл ажиллагаагаа явуулж байгаа. Тэгээд бас олон улсын хамтын хэлэлцээр дипломат шугамаар байгуулагдсан энэ гэрээний хүрээнд Боловсролын сайдын багцаас бас татаас түшиц эмнэлэгт үзүүлэх дэмжлэг явагддаг. Тэгээд энэ удаагийн төсвийн тодотголд бол бас 576 сая төгрөгийн одоо хэмнэлтэд орж бууралт орсон байгаа. Хүний нөөцийн тухайд бол ямар нэгэн хөндөлт энэ талаар бол одоо бүтцэд өөрчлөлт орох ч байдаг юм уу, ямар нэгэн хүний нөөцийг цомхотгох, хязгаарлах ийм асуудал бол хөндөгдөөгүй ээ.

Д.Батбаяр: Прокурорын байгууллагын хүний нөөцийн талаар Хууль зүйн яамныхан хаа байна? Хууль зүйн яам 9 номерын микрофон дээр суучих. Хууль зүйн бодлогоос нь газраас нь асуучихъя. Ажлын хэсгийн 9 номерын микрофоныг нээе.

С.Гансэлэм: Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга Гансэлэм байна. Гишүүний асуултад хариулъя. Прокурорын байгууллага нийт батлагдсан орон тоогоор 709 прокурорын орон тоотойгоор үйл ажиллагаа явуулдаг. Тэгэхээр энэ орж ирсэн төсөл дээр 114 прокурорыг хасахаар төсөл дээр санал орж ирсэн. Ингээд энийг тооцоод үзэхээр нийт 16 хувь болчихоод байгаа юм. Улсын хэмжээнд 709 прокурор л ажиллаж байгаа, маш цөөхөн шүү дээ. Тэгэхээр үүнээс 114-ийг нь хасчихаар ингээд нэг 16 хувь болчихдог. Тэгэхээр энэ байдлаар бас үйл ажиллагаа явуулах үнэхээр боломжгүй ээ гэж прокурорын байгууллагын хувиас бол үзэж байгаа.

Тэгээд прокурорын байгууллагын мэдээж энэ 709 прокурорын үйл ажиллагаанд хяналт тавьдаг хэргийн тоо баримт гээд тодорхой цөөхөн юмнууд хэлэх юм бол зөрчлийн болон эрүүгийн хэргүүд дээр 3416 хэрэгт хяналт тавьж ажиллаж байгаа 709 прокурор. Үүнээс 114-ийг нь хасчихаар үнэхээр энэ прокурорын хяналтын үйл ажиллагаа.

Д.Батбаяр: 9 номерын микрофон гүйцээж хариулна.

С.Гансэлэм: Боломж нөхцөл үнэхээр байхгүй болж байгаа. Та бүхэн энэ тооноос ч гэсэн харж байгаа байх. 709 үүнээс 114-ийг хасахаар 16 хувь прокуроруудын 16 хувь нь үндсэндээ энэ цомхотголд орохоор ийм саналтай байгаа. Тэгэхээр энийг бас нэг анхаарч үзэх нь шаардлагатай гэсэн саналтай байна.

2 дугаарт энэ прокурорын байгууллагын төсвийн тодотгол дээр нийт 13 тэрбум орчим хасагдаж байгаагаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал бүүр тэг болж орж ирж байгаа. Тэгэхээр прокурор өөрөө энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал гэдэг маань прокурорын хяналтын үйл ажиллагаа явуулах үндсэн зардал байдаг. Тэгэхээр энэ зардлыг үнэхээр одоо тооцож тавьж, буцааж харгалзаж үзэхгүй болбол бас үйл ажиллагаа явуулах ямар ч боломжгүй байгаа гэсэн ийм зүйлүүдийг нэмж хэлье ээ.

Д.Батбаяр: За баярлалаа. Энэ Гансэлэм дарга байна уу? Прокурорын байгууллагын та. Цогтбаатар гишүүн тодруулж асууна аа. Цогтбаатар гишүүний микрофон тодруулга.

Да.Цогтбаатар: Өмнө нь 2025 оны төсвийг 2024 онд хэлэлцэж байхад бас яг энэ асуудлыг ярьж байсан. Хуулийн байгууллага дээр яг нөгөө зардал мөнгө нь хүрдэггүй, хүн хүч нь хүрэлцээгүй байдаг гэдэг дээр. Тэгээд захиргааны албан хаагчийн тоо гэдэг нэг ийм мэргэжлийн бус орон тоо нэлээдгүй одоо энэ салбар болгон байгууллага болгон дээр байгаад байгаа юм. Тэгээд нөгөө нисдэг бор морийг нь алаад ир гэхээр нисдэггүй бор морийг нь алчаад ирлээ гэдэг шиг хэрэггүй орон тоогоо хасаач гэхээр энэ хэрэгтэй орон тоогоо хасаад байдаг дээр энэ Засгийн газар онцгой анхаарахгүй болбол ажил хийдэг хүмүүс чинь өөрөө цөөрөөд ажил хийдэггүй тийм. Одоо энэ Монгол, Японы эмнэлэг болбол яг баримттай кэйс байгаа. Тэгээд тэнчээнээс жишээлэхэд захиргааных нь орон тоо нэмэгдээд байхад нарийн мэргэжлийнхээ одоо энэ прокуроруудын орон тоог хасна гэж байгаа дээр нэг л байгаа онохгүй хэмнэлт, орон тооны хасалт явагдаад байгаа гэдгийг энэ Засгийн газар дахин харж нягтлахгүй болбол нэлээн одоо ийм өрөөсгөл тоонууд хас гээд нөгөө нисдэг нисдэггүй бор морины асуудал л яригдах гээд байгаа гэдгийг...

Д.Батбаяр: Та хариулах уу? Санал байлаа. За гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.5 дахь хэсэгт заасан бусад Байнгын хороо Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд гишүүн нам, эвслийн бүлэг, төрийн аудитын төв байгууллага саналаа зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт гаргана аа гэж заасны дагуу санал гаргах гишүүн байна уу? За санал гаргах гишүүн байхгүй байна.

Төсвийн тодотгол төсвийн тодотголын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос гаргах санал дүгнэлтийг УИХ-ын Цогтбаатар гишүүн Төсвийн байнгын хорооны хуралдаанд та уншиж танилцуулна аа.

Тодотгол хэлэлцэж байхад тодотгол. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

10:48

Д.Батбаяр: Дараагийнхаа асуудалд орно оо.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Монгол УИХ-ын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье ээ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг өмнөх хэвээрээ байгаа учраас танилцуулах шаардлагагүй юм байна тиймээ.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74.4.2 дахь хэсэгт заасны дагуу Байнгын хороо төсвийн гүйцэтгэлээ хэлэлцэж санал дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Нэгдсэн төсвийн 2024 оны гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна аа. Жавхлан сайдын микрофоныг нээгээрэй.

Б.Жавхлан: За баярлалаа. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.3 дахь заалтад Аудитын дүгнэлт гарснаас хойш ажлын 7 өдөр дотор нэгдсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг аудитын дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, 8.10.4 дэх заалтад Улсын Их Хурал Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хаврын чуулганаар хэлэлцэн улсын төсвийн гүйцэтгэлийг батлах гэж заасны дагуу Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг та бүхэнд танилцуулж байна аа.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвийн 39 төсвийн ерөнхийлөн захирагч, 21 аймаг, сум, нийслэл, дүүргийн нийт 3718 төсөвт байгууллага болон Үндэсний баялгийн сан, Төсвийн тогтворжуулалтын сан,

Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийг нэгтгэлээ. Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд 5559 төсөвт байгууллага, 349 төсөл сан, төрийн өмчийн 638 ААН-ийн тайланг хамрууллаа. Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 онд 27.4 тэрбум ам.доллар болж өмнөх оноос 12.1 хувиар өссөнөөр гадаад худалдааны тэнцэл 4.2 тэрбум долларын ашигтай гарлаа. Экспорт өмнөх оны мөн үеэс 3.9 хувиар өсөж 15.8 тэрбум долларт хүрэхэд зэсийн баяжмал, алт, төмрийн хүдрийн экспортын өсөлт голлон нөлөөллөө. Төлбөрийн тэнцэл 622 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн жил 4.9 тэрбум доллар байсан гадаад валютын улсын нөөц 2024 оны эцэст 5.5 тэрбум долларт буюу түүхэн дээд хэмжээндээ хүрсэн байна аа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2024 онд 29 их наяд 670.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 30 их наяд 591.1 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцлийн 2 их наяд 451 тэрбум төгрөгөөр сайжирч, 920.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ба сүүлийн 3 жил дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулж ажиллалаа. Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 20 их наяд 533 тэрбум төгрөг, зарлага 20 их наяд 372.4 тэрбум төгрөг нийт тэнцэл 1 их наяд 220.8 тэрбум төгрөгөөр сайжирч, улсын төсөв 1 их наяд 283.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

2024 онд авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнүүдээс тоймловол Эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх бодлого, тэргүүлэх чиглэлийн хүрээнд өмнөх онуудад авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг хадгалж, макро тогтвортой орчныг дэмжсэн төсөв мөнгөний бодлогыг хэрэгжүүлэн үргэлжлүүлэн улсын зээлжих зэрэглэлийг ахиулах зорилт тавьж ажилласны үр дүнд олон улсын зээлжих зэрэглэлийн “Fitch Ratings” болон Эс Энд Пи Глобал рейтингс агентлагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг би нэмэх “Мудиз” агентлаг. В 2 тогтвортой болгон тус тус нэг шатлалаар нэмэгдүүлэн сайжруулсан. Энэ нь Монгол Улсын гадаад шууд хөрөнгө оруулалт татах, олон улсын санхүүгийн зах зээлээс хүүд багатай, санхүүжилт босгох боломжийг нэмэгдүүлэх, улмаар төсөв, төлбөрийн тэнцэл, валютын ханшид эерэг нөлөө үзүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлж байна.

Засгийн газраас авч хэрэгжүүлсэн өрийн зохицуулалтын арга хэмжээний хувьд жил ирэх тусам эрсдэлийн нэмэгдлийг бууруулж байна. Энэ нь ам.долларын эрсдэлгүй хөрөнгө оруулалтын өгөөжөөс давж буй хүүгийн хэмжээг харуулах бөгөөд бөгөөд Монгол Улсын Засгийн газрын хувьд 2021 онд гаргасан үнэт цаасны хувьд 3.6 хувьтай, 2023 онд гаргасан үнэт цаасны хувьд 3.6-4.9 хувьтай, 2025 онд гаргасан үнэт цаасны хувьд 2.3 хувьтай тус тус тэнцэж байна аа. Энэ нь олон улсын зах зээлд тогтмол оролцож хөрөнгө оруулагчдын итгэх илтгэлийг итгэх итгэлийг нь нэмэгдүүлж байсантай шууд холбоотой юмаа. За ингэснээр 2025 онд 8.5 хувьтай гарах боломжтой байсан үнэт цаасны хүүгийн түвшнийг 6 бүхэл 6.25 болгон бууруулсан ач холбогдолтой болно оо.

УИХ-аас 2024 онд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, Ирээдүй өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоо бий болсон. Хууль батлагдсантай холбогдуулан Үндэсний баялгийн төрөлжсөн сангийн дансыг Монгол банканд байршуулж, тайлан тоонд 1 их наяд 341.9 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 495.6 тэрбум төгрөгийг Монголбанктай гэрээ байгуулан, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж ажилласан бөгөөд оны эцсийн харилцах дансны үлдэгдэл 3 их наяд 979.4 тэрбум төгрөг боллоо болсон. Засгийн газрын 2024 оны 224 дүгээр тогтоолоор Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын

нэрийн данс үүсгэх, хөтлөх сангаас зарцуулалт хийх журмыг баталж, хуримтлалын сангаас нэрийн данс үүсгэн иргэн бүрд 138 мянга 993 төгрөгийг хуваарилсан болно оо.

Засгийн газрын хилийн боомтуудын нэвтрэх хүчин чадлыг нь сайжруулж, Замын-Үүд, Гашуунсухайт боомтын импортын тээврийн хэрэгслийн 9 гарцыг 2023, экспортын 5 гарцыг 27, нүүрс тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх экспортын 6 гарцыг 10 болгон өргөтгөж, Шивээхүрэн боомтын хилийн шалган нэвтрүүлэх 8 хаалгыг шинээр ашиглалтад оруулснаар экспортыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажилласан. Үүний үр дүнд 2024 онд нүүрсний экспорт 83.8 сая тоннд хүрч, өмнөх оноос 20 хувиар нэмэгдлээ. ОТ далд уурхайн нөлөөллөөр зэсийн баяжмалын экспорт 2024 онд 1 сая 695 мянган тоннд хүрч өмнөх оноос 11 хувиар, олборлолт нэмэгдсэнтэй холбоотойгоор төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 7 сая 511 аравны мянган тоннд хүрч өмнөх оноос 31 хувиар тус тус өссөн.

Иргэдийн нийгмийн баталгааг сайжруулах, төрийн албан хаагчдын цалин нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх хүрээнд төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар, нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр, тэтгэмжийг 100 мянган төгрөгөөр нийгмийн халамжийн сангаас олгож байгаа 4 төрлийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 10 хувиар нэмэгдүүллээ. Орон нутагт ажилласан нэмэгдлийг хөдөөгийн сум ажиллаж байгаа төрийн захиргааны үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдад тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар, аймгийн төв болон нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргааны үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдад тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар бодож сар бүр олгохоор шийдвэрлэсний дагуу 101.4 мянган төгрөгийн төрийн албан хаагчдад улсын төсвөөс 239.9 тэрбум төгрөгийн нэмэгдэл олгосон байна аа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд нийт 1320 төсөл арга хэмжээнээс шинээр хэрэгжүүлсэн 712 төсөл арга хэмжээнд 1 их наяд 687 тэрбум төгрөг, өмнөх онуудаас шилжин хэрэгжиж буй 607 төсөл арга хэмжээнд 1 их наяд 406.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгож, гүйцэтгэл 80.3 хувийн биелэлттэй байна аа.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан танилцуулгатай танилцаж, Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Д.Батбаяр: Сангийн сайдад баярлалаа. Одоо Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна аа. Ажлын хэсгийн 5 дахь микрофоныг нээе.

С.Магнайсүрэн: Зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль хуульд заасны дагуу Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гарган аудитын тайланг хуулиар тогтоосон хугацаанд УИХ-д хүргүүлсэн.

УИХ-ын эрхэм гишүүд та бүхэнд аудитын тайлан дүгнэлтийн талаар хураангуйлан танилцуулъя.

1.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын талаар. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан тусгай шаардлагуудыг хангасан байна.

2.2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд гүйцэтгэлд хийсэн аудитаар нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 29 их наяд 670.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 30 их наяд 591.1 тэрбум төгрөгөөр баталгаажууллаа.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн өмнөх оноос 29 хувиар өсөж, тайлан онд төлөвлөснөөс 534.5 тэрбум төгрөгөөр тасарсан боловч Үндэсний баялгийн санд 1 их наяд 341.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 30 их наяд 591.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 35.9 хувиар өссөн нь цалин хөлс 3 их наяд 41 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 2 их наяд 782.6 тэрбум төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 1 их наяд 430.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна аа.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийг 3 их наяд 371.3 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 920.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь ДНБ-ий 1.2 хувьтай тэнцүү байна. Засгийн газрын өрийн нэрлэсэн үнээр илэрхийлсэн үлдэгдэл 33 их наяд 399.9 тэрбум төгрөг болж, ДНБ-ий 41.8 хувьтай тэнцэж, өрийн үлдэгдэл өмнөх оноос 2 их наяд 626.3 тэрбум төгрөг буюу 8.5 хувиар өссөн байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд 27 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тухайн онд шинээр хэрэгжих 712, он дамжин хэрэгжих 677 нийт 11 их наяд 579.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 1319 төсөл арга хэмжээг тайлант онд 3 их наяд 828.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 62.7 хувийн санхүүжилтийг олгож, хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн 579 төсөл арга хэмжээний хэрэгжилт 69 хувьтай буюу хангалтгүй байна аа.

Аудитаар УИХ-д 4 асуудал толилуулж, Монгол Улсын Ерөнхий сайдад 14, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 2, Сангийн сайдад 15, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад 1, Хууль зүй, дотоод хэргийн сайдад 1, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний үндэсний хорооны даргад 2, Эрүүл мэндийн сайд бөгөөд ЭМД-ын Үндэсний зөвлөлийн даргад 1, бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарт 4 зөвлөмж тус тус өгч, аудитын тайланд тусгалаа.

2.Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн талаар.

Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, нийгмийн даатгалын сан, ЭМД-ын сан, улсын болон орон нутгийн 61 төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэдгээрийн харьяа байгууллагуудын нийт 6832 санхүүгийн тайланг аудитад хамруулсан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өөрчлөлтгүй 33, хязгаарлалттай 29, сөрөг нэг дүгнэлт өглөө. Аудитаар илэрсэн зөрчлөөс 27.1 тэрбум төгрөгийн зөрчилд 2364 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг таслан зогсоох 4686 албан шаардлага хүргүүлж, 1 их наяд 618.1 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 6013 зөвлөмж өгч, 60 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 165 албан тушаалтанд хариуцлага тооцуулах, 151 албан шаардлага хүргүүлж, хууль хяналтын байгууллагад 10.2 тэрбум төгрөгийн 26 зөрчлийг шилжүүлээд байна аа.

Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчил нь санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул хязгаарлалттай дүгнэлт өгсөн байна аа. Аудитаар УИХ-д нэг асуудлыг толилуулж, Монгол Улсын Ерөнхий сайдад 6, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 3, Сангийн сайдад 3 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг УИХ-ын нэгдсэн хуралдаан болон Байнгын хороодод танилцуулаад байна аа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Батбаяр: Монгол Улсын Ерөнхий аудиторт баярлалаа. Тэгээд одоо хэлэлцэж байгаа энэ Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх Сангийн сайдын илтгэл болон Аудитын дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя аа. 3 гишүүн надтай нийлээд 4 гишүүн. Цогтбаатар гишүүнээр тасалъя. Та байгаа юу? Пүрэвдаваа гишүүнийг оруулаад нийт 5 гишүүн асуулт асуух нь байна аа. Хамгийн түрүүнд ирцээрээ Батболд гишүүн асуулт асууна.

Р.Батболд: Өдрийн мэнд хүргэе ээ та бүхэндээ. Зүгээр товчхон нэг хоёрхон асуулт л асуух гэсэн юм. Энэ аудитын дүгнэлтээр алдаатай зөрчилтэй гээд нэлээдгүй хэмжээний одоо юу гарч ирээд байна л даа дүгнэлт гарч ирээд байна л даа. Тэгээд энэ дээр ер нь хариуцлагыг нь яах юм бэ гээд. Алдаатай нь яах вэ тэгээд засагдаад явна биз. Зөрчилтэй дүгнэлттэй одоо тэрнийхээ хариуцлагыг ер нь яаж хүлээлгэх юм. Энэ засаг маань нэг 3 сар, 6 сар гээд ингээд нөгөө хариуцлага хүлээдэг дарга нараа сольчихоод байхаар энийг ер нь нөхөж яаж хариуцлага хүлээлгэх юм бэ? Шийдвэр гаргасан улсуудад нь ямар хариуцлага тооцох юм. Энэ дээр та нарт нэг бодсон юм байна уу? гаргалгаа байна уу? Яг шууд хариулт өгчих боломжгүй байвал би нэг чуулганы бас танхимд асууя гэж бодож байгаа. Тэрэн дээр сайн бэлдээд одоо хариулт өгчих боломжтой байвал хариулаад өгөөрэй гэж хэлэх гээд байгаа юм.

Хоёрдугаарх нь, одоо энэ дүгнэлтүүд дээр бас л ялгаагүй нөгөө гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдтэй холбоотой бас их зөрчлүүд гараад ирчихсэн байгаад байгаа. Тэгэхээр Сангийн яам сайдаасаа ч гэсэн бас давхар асуучихмаар байна. Бид нар энэ зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдээ ашиглалтыг нь сайжруулъя аа гээд ингээд нэмэгдүүлье ээ бид нар ашиглаж чадахгүй байна аа гээд байдаг. Нөгөө талдаа хэрэгжиж байгаа төслүүд маань өөрсдөө ингээд хугацаандаа ч ордоггүй. Ингээд хугацаа нь хойшлоод яваад

байхаар бид нарын бас ашиглах зээлийн хэмжээ чинь хойшлоод л тэрэндээ бас хий төлөөд л яваад байдаг. Энэ дээр ямар гаргалгаа гаргах юм. Анхнаасаа Сангийн яам маань хэлэлцээрээ хийхдээ тэр ерөнхий гэрээн дээрээ энийгээ тусгаж болдоггүй юм уу, энэ чинь хугацаатай байх ёстой шүү гэдгээ зааж болдоггүй юм уу? Тэгээд гараад ирэхээр бид нар нэг баахан зээлээ хэрэглэж чадахгүй баахан мөнгө төлөөд байдаг, хэрэгжүүлж байгаа төслүүд нь хугацаандаа явдаггүй ийм асуулт асуудлуудаас болоод аудит дээр бас ийм дүгнэлтүүд гарч байгаа байх аа гэж бодож байна. Тэгээд ийм 2 асуултад хариулаад өгөөч.

Д.Батбаяр: Энэ зээл тусламжтай холбоотой асуудал дээр нь Сангийн яам Сангийн сайд хариулъя. Сангийн сайдын микрофоныг нээгээрэй.

Б.Жавхлан: Батболд гишүүний энэ шүүмжлэлтэй асуудал дээр бол 100 хувь санал нийлж байна аа. Одоо энд байгаа манай сайд нар алга байна. Төрийн нарийн бичгийн дарга, яамдууд энийг анхааралтай сонсох ёстой шүү. Сангийн сайд тэр одоо ингээд энэ жилд ч өнгөрсөн оны гүйцэтгэл дээр 4.9 их наяд төгрөгийн багц байгаа юм. Үүнийх чинь ингээд 2 их наяд нь гадаад зээл тусламжийн ашиглалт 1.5 их наяд нь гадаад зээлийн төлбөр хүү байж байдаг. Тэр 2 их наяд төгрөгийн гадаад зээлийн тусламжийн ашиглалт дотор бүх яамдууд дээр хэрэгжиж байгаа бүх төсөл хөтөлбөрүүд энэ дотроо багтаж байдаг. Энэ төслийг хэрэгжүүлж байгаа, дамжуулж байгаа сайд нар цаад гүйцэтгэгчтэйгээ, цаад зээлдэгчтэйгээ одоо гэрээгээ хийсэн байдаг. Энэ гэрээнийхээ хэрэгжилтэд хариуцлага хүлээдэг байх хэрэгтэй шүү. Хугацаа чанар гүйцэтгэл дээр. Сангийн яаман дээрээс бид нар төсвийн хуваарилалтаараа л энийг хянаана. Яг гүйцэтгэлийг нь бол чанар стандартыг нь болбол яамдууд гэрээлэгч дамжуулагч төсвийн эрхлэгч нар энэ дээр хариуцлага хүлээх ёстой. Маш хариуцлагагүй олон төслүүд байгаа. Гүйцэтгэл нь муу, энийг нь хойшлуулъя, зогсооё гэхээр нэг их олон эздүүд гарч ирээд энүүгээр ингээд одоо төрийн ордноор лоббидоод гүйгээд байдаг. Одоо цаашдаа бид 12 их наяд буюу 12 их наядын төсвийн алдагдлыг ойрын жилүүдэд хүлээх шаардлагатай болж ирж байгаа. Энэ төслүүдийг санхүүжүүлэхийн тулд энэ бол өөрөө маш улс төр дагуулдаг. Цаана нь одоо манай яамдууд чив чимээгүй. Ингээд нуугдаад ямар ч хариуцлага байхгүй. Нэг хэдэн гүйцэтгэгч нартайгаа хуйвалдаад ингээд үлддэг шүү. Энэ дээр нийслэл ч гэсэн хамаарна.

Сая ковидын жилүүдэд яах вэ дэлхий нийтээрээ л энэ үнийн цохилтод орлоо. Төсөвт өртгүүд бол нэмэгдсэн. Тэрэнтэй ч холбоотой энэ одоо хүлээгдэж байгаа гадаад зээлийн ашиглалт тусламжийн дүн өссөн. За гэсэн хэдий ч ашиглалт, чанар, гүйцэтгэл хамгийн чухал байгаа шүү. Би Их Хурлын өмнө хариуцлага хүлээнэ. Гэхдээ бидний өмнө энэ төсвийн ерөнхийлөн захирагч нар цаад одоо төсөвтэйгөө, цаад улстайгаа, цаад байгууллагатайгаа гэрээ хийсэн сайд нар бас хариуцлага хүлээх ёстой шүү бид нарын өмнө. Бүгд нуугдаад үлдчихдэг. Хэн нь ч юу ч мэдэхгүй, чадахгүй болоод явчихдаг. Тэгэхээр одоо энэ төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа одоо төсвийн шууд...

Д.Батбаяр: Саяын ашиглалттай холбоотой Сангийн сайдын хариулсан асуултад нэмж хариулах байгууллага байна уу? За тэгвэл 2 дахь асуулт. Энэ хариуцлагатай холбоотой асуудал дээр ажлын хэсгийн 5 номер аудитын газар хариулна.

С.Магнайсүрэн: Батболд гишүүний асуултад хариулъя. Аудитаар гарч ирж байгаа зөрчлүүд одоо бүх л Байнгын хороон дээр яригдаад, энэ хариуцлагын асуудал нэлээн сөхөгдөж байгаа, сөхөгдөж тавигдаж байгаа. За өнөө бид нарын

хувьд болбол аудитын сая миний одоо хэлсэн дээр жишээлбэл хариуцлага тооцуулахаар 151 одоо 165 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар бид нар асуудлаа тавьчихсан. За хууль хяналтын байгууллагад 26 асуудлыг 10.2 тэрбум төгрөгийн асуудлыг тавьчихсан байж байгаа юм. Өнөөдрийн манай хуулиар бол ер нь өөрчлөлтгүй, хязгаарлалттай, сөрөг дүгнэлт өгөхөөс татгалзсан гэсэн ийм 4 дүгнэлт байгаа. Дүгнэлт өгөхөөс татгалзсан тохиолдолд болбол ажлаас халах арга хэмжээ авах ёстой шууд. Сөрөг дүгнэлт дээр болбол арга хэмжээ авах ёстой. Энийг нь болбол эргээд аудитын байгууллага бүртгэл хяналтдаа авна. Өөрчлөлтгүй, хязгаарлалттай 2 дээр бол ямар нэгэн арга хэмжээ бол байдаггүй хуулиараа. 2020 онд Аудитын тухай хуулийн өөрчлөлтөөр хязгаарлалттай дүгнэлт дээр арга хэмжээ байсан нь хасагдсан юм байна лээ.

Тэгэхээр хүмүүс одоо гишүүдийн ярьж байгаа болбол энэ хязгаарлалттай дахин дахин аваад байгаа тохиолдолд яагаад арга хэмжээ байдаггүй юм бэ гэдэг ийм асуудал яригддаг юм байна лээ. Энэ талаар бид нар хуулийн өөрчлөлт энэ тэр байвал дараа нь бас сөхөж ярих шаардлага гарах байх. Зүгээр бид нарын хувьд болбол нэг асуудлыг давтаад энэ жил гаргаад, хойтон дахиад хязгаарлалттай авч байвал энэ дээр бид нар арга хэмжээ сөхөж ярихаас өөр гарцгүй. Яагаад гэвэл давтаж байгаа учраас гэдэг байдлаар асуудалд хандах ийм зайлшгүй шаардлага үүсэх юм байна лээ. Ер нь болбол хариуцлагын асуудал дээр бид нар цаашдаа одоо жишээлбэл манайх бүтцийн өөрчлөлтөөрөө болбол энэ шийдвэрийн хэрэгжилтийн ийм нэгжтэй болж байгаа энэ чиглэл дээр бид нар онцгойлон анхаарч ажиллана цаашдаа ингэж бодож байгаа.

Д.Батбаяр: Батболд гишүүн тодруулж асууна аа.

Р.Батболд: Үгүй яах вэ нөгөө аудитын газрынхныг ойлгож байгаа. Бид нар чинь дандаа нөгөө ардаас нь аудит хийгээд яваад байдаг. Зөрчил гаргачихсан албан тушаалтан нь байхгүй байхад нөгөө ажлаас халах гэдэг юм өгөөд ч хэрэг байдаг юм уу, үгүй юу гэдэг л асуудал яриад байгаа байхгүй юу. Тэгэхээр зөрчил гаргаад ингээд явчихсан албан тушаалтны тушаалтанд яаж одоо эргүүлж гэх юм уу, нөхөж гэх юм уу хариуцлага тооцох ёстой юм бэ л гэдэг юм асуугаад байгаа юм. Түүнээс биш яах вэ одоо ингээд ажлаа авчихсан одоо жишээлэх юм бол юу гэдэг юм нэг дөнгөж сая Засаг газар байгуулагдлаа. Энэ дээр нэг дүгнэлт гараад л ирвэл энэ чинь дөнгөж ажлаа авсан хүмүүст нь арга хэмжээ тооц гээд л гараад ирэх нь байна шүү дээ гэдэг л зүйл асуугаад байгаа байхгүй юу. Тэгэхээр ерөнхийдөө ямархуу гарц гаргалгаа байх юм. Тэр зөрчил гаргасан улсуудтай нь яаж эргэж хариуцлага тооцох юм бэ гэдэг л асуудал асуугаад байгаа юм.

Д.Батбаяр: Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг нээе. Магнайсүрэн дарга.

С.Магнайсүрэн: Батболд гишүүний асуултад хариулъя. Хууль хяналтын байгууллагад шилжиж байгаа буюу гэмт хэргийн чанартай асуудал байхад бол тэр хүн ажлаас чөлөөлөгдсөн байна уу, чөлөөлөгдөөгүй байна уу энэ болбол эрүүгийн болон бусад процесс хууль тогтоомжид заасны дагуу шалгагдаад, холбогдох арга хэмжээ нь юу шийтгэл хариуцлагууд бол хүлээнэ. Зөрчил гаргасан субъект нь байхгүй тохиолдолд тухайн тэр байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд буюу одоо нягтлан байдаг юм уу, санхүүгийн юу байдаг юм уу, тэд нар дээр бас асуудал яригдана. Оролцооны хэмжээгээр. Зүгээр ер нь зөрчил гаргасан хүн нь явчихсан тохиолдолд л бол байна. Одоо жишээлбэл өнөөдөр бид нар ингээд 11 сард солигдчихсон Засаг дарга нь солигдчихсон.

Гэтэл бид нар 2 сард ингээд арга хэмжээ тооцуулах юм явах гэхээр хүн нь солигдоод үндсэндээ өмнөх хүнийх нь гэм буруу болж хувирч байгаа учраас Засгийн газрын Хэрэг эрхлэх газар луу асуудал тавих үед ийм тайлбар жишээлбэл ирж байгаа тохиолдол байна. Энэ тохиолдол бол бид нар тэр хүн улс төрийн хариуцлагаа хүлээгээд ингээд явчихсан байгаа тохиолдолд бол бид нар арга хэмжээ авч бас чадахгүй байгаа. Ийм хууль зүйн хувьд бол тодруулах шаардлагатай зүйл бас бүрхэг. Ийм тодруулах шаардлагатай зүйл бас байна. Бусад тохиолдолд болбол одоо Аудитын тухай хууль болон бусад хуульд заасан хариуцлагууд хүлээгээд явах ийм бололцоо байгаа. Төсвийн тухай хуульд бол энэ хариуцлагын асуудал бол 70 дугаар зүйл дээр маш тодорхой заагдсан ийм байдаг юм байна лээ. Хариулж дууслаа.

Д.Батбаяр: Хэн чинь 70 дугаар зүйл дээр чинь томилохдоо гэж байгаа болохоос биш яг гүйцэтгэх ажил гүйцэтгэж явсан хүнийг яг ажлаас халдаг шалтгаан нь энэ танай дүгнэлт болдог болов уу? Байхгүй тиймээ, тэр заалт нь байхгүй тиймээ. Ажлын хэсгийн саяынх. Та дараа нь намайг асуулт асуухад харин нэмээд хариулчхаарай тиймээ. Одоо Батжаргал гишүүн маань асуулт асууна аа.

Ж.Батжаргал: За баярлалаа. Гишүүдийнхээ амрыг эрье. Төсвийнхөө хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал бидэнд байгаад байх шиг байгаа юм. Дам дамаа энэ төсвийн гүйцэтгэлийн явц, гүйцэтгэл, тайлагналын асуудлыг төсвийн тухай хуульдаа нэг бүлэг болгож, ер нь нэлээн процессжуулж оруулахгүй бол болохгүй болчихоод байна л даа. Ядаж хагас жилээр энэ мэргэжлийн Байнгын хороод нь өөрийнхөө эрхлэх хүрээний салбаруудынхаа төсвийн явцыг нэг сонсоод тодорхой чиглэл юмнууд өгч, төсвийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай асуудал байгаад байгаа юм. Гүйцэтгэл тайлагналтаар дүр зургаа олж хараад, дараа дараагийн жилийн төсвийн төлөвлөлт юмнууд дээрээ анхаарах асуудлуудаа шийдэж явах ёстой юм. Тэгэхээр энүүнийг бол манай Их Хурал, дам дамаа Төсвийн зарлагын хяналтын дэд хороо бид л одоо анхаарч, төсвийн хуулиа боловсронгуй болгох асуудал байх шиг байна гэж. Энэ дээр одоо даргын санал бодол ямархуу байгаа юм гэж?

Дараагийн нэг зүйл амьдрал үргэлжилж байгаа юмаа. Тэгэхээр зэрэг тодорхой зүйлүүдтэй нүүр тулаад байна. Дам дамаа давагдашгүй гэдэг юм уу, давтагдашгүй хүчин зүйлүүдийн улмаас хамаараад Төсвийн тогтвортой байдлын тухай хууль ч гэдэг юм уу, Төсвийн хуультайгаа зөрчилдсөн бодит амьдрал нүүр тулж байгаа юм. Одоо энэ жилийн хувьд 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсөөллийг тодотгож байж 2026 оны төсөв боловсрогдох шаардлагатай болчихоод байгаа байхгүй юу. Гэтэл одоо бид Их Хурлаар тодотгочихъё гэхээр 3 сарын дотор төсвөө өргөн барьж чадахгүй болчихоод байгаа байхгүй юу. Байдал үнэхээрийн нөхцөл байдал нь хүндрээд, орох орлого юмных нь босго буугаад ирчихсэн л юм бол одоо бид бодитой төсөв боловсруулахын тулд төсвийн хүрээний мэдэгдэлдээ тодотгол хийхээс өөр аргагүй л болчихож байгаа байхгүй юу. Тэгээд тэрийг дагаж төсөв боловсрогдох ёстой энэ мэтчилэнгээр ийм юмтай нүүр тулбал яаж болох юм гэдэг зохицуулалтыг нь энэ хуульд шингээж өгөхгүй бол амьдрал болохгүй байна аа. Энүүнийг одоо бас би Төсвийн зарлагын хяналтын дэд хороо бид анхаарах ёстой болов уу гэсэн нэг ийм бодол байна.

За 2 дахь, 3 дахь яг асуултын шинжтэй юм руугаа ормоор байна. Төсвийн захирагчдын болон санхүүгийн ажилтнууд мэргэжлийн ур чадвар, хариуцлага сахилга, тогтвортой байдлыг хангах талаар ер нь энэ улсын хэмжээнд ямархуу бодлого баримтлал яваад байгаа юм. Бид хэд чинь одоо бас дижитал шилжилт

цахим засаглал гээд дам дамаа манай санхүүгийн салбар төсвийн салбар бол энэ тал руугаа нэлээн орчихсон нэгдсэн программ хангамжтай болчихсон. Тэр программыг нэлээн боловсронгуй болгож аль болохоор зөрчилтэй санхүүжилт юмнууд гардаггүй байх. Тайлагнал өөрөө стандарт хангагдаагүй бол бас нэгтгэлд орж ирж чаддаггүй байх энэ тэр ийм...

Д.Батбаяр: Батжаргал гишүүний хэлж байгаа бол яах аргагүй үнэн. Яалт ч байхгүй 2 удаа сонгогдчихсон ийм төсвөөр мэргэшчихсэн ийм гишүүн учраас маш чухал асуудлыг хөндөж байгаа. Бид нар чинь одоо 6 сар өнгөрчихсөн шүү дээ 6 сар өнгөрчхөөд байхад одоо бид нар гүйцэтгэлээ хэлэлцэж байна. 19-нд аудитын байгууллагын дүгнэлт өгснөөс хойш бид нар одоо ерөөсөө хэдхэн хоногийн хугацаанд хэлэлцээд 600 орчим материалыг хэлэлцээд, тэгээд чуулган руу оруулахад хангалттай хугацаа биш болчихож байгаа юм. Тэгэхээр яах аргагүй энэ дэгтэй холбоотой. Энэ төсвийн хяналт төсвийн зарлагын хяналтыг сайжруулах, илүү боловсронгуй болгохдоо одоо хийх ажил маш их байна. Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах хэрэгтэй байна. Сая асуулт дээр 2 дахь асуулт дээрээ ч гэсэн бас хэлж байна. Энэ дижитал хувьсал ажил үүрэгтэй бүгдэд нь яаж бид нар энэ орчин үеийн технологийн хөгжлийг хамруулах вэ гэдэг дээр болбол үнэхээр хийх ажлууд маш их байгаад байгаа юм. Үүн дээр болбол бас энэ аудитын Үндэсний аудитын газар ч гэсэн бас тодорхой хэмжээгээр бас шинэ санал боловсруулаад сая тогтоолын төсөл боловсруулаад явж байгаа.

Зарлагын хяналтын дэд хороо ч гэсэн одоо цаг хугацааны хувьд одоо яг энэ хаврын чуулган маань өөрөө боломжгүй болчихоод байгаа учраас намар бид нар энэ тогтоолын төслийг оруулж ирэх юм. Энэ дээр бол Батжаргал гишүүнийг бас оролцоод өөрийнхөө үйл хэргээрээ яг санаачлаад ахлаад яваасай гэж бас хүсэж байгаа. За 2 дахь асуулт, 2 дахь асуултад Аудитын байгууллага хариулах уу? 5 номерын микрофоныг нээе

С.Магнайсүрэн: Алдаа зөрчилтэй холбоотой асуудлыг бол одоо бүх Байнгын хороод дээр энэ талаар нэлээн тодорхой саналууд гаргаж, чиглэл өгсөн учраас бид нар энэ алдаа зөрчлийн асуудлыг нэгтгэж хяналтдаа авч, хэрэгжилтийг хангах чиглэлээр бол онцгойлон одоо энэ чиглэлийнхээ ажлыг бол шинэ шатанд гаргана гэж төлөвлөж, бүтэц зохион байгуулалтын чиглэлд бас боловсронгуй болгосон. Тэгээд хэрэгжилтийнх нь мэдээллийг шаардлагатай бол бид нар Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, Төсвийн байнгын хороон дээрээ мэдээлж цаашдаа явах ийм бололцоо бол бид нарт бүрэн дүүрэн байгаа.

Хариуцлагатай холбоотой асуудал дээр Аудитын тухай хуульд заасан болоод төсвийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх үндэслэлүүд бол байгаа. Тэгэхдээ аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй тохиолдолд одоо тохиолдлууд бол элбэг байна. Одоо жишээлбэл аймгийн дарга нар дээр тавигдсан аудитын шийдвэрүүд хэрэгжилт их тийм тааруу, их бага хувьтай. Зарим зөвлөмжүүд одоо зарим эрх бүхий этгээдүүд дээр ч гэсэн одоо Засгийн газрын гишүүд энэ тэр дээр бол бага үеийн хэрэгжилттэй ингэж гарч ирж байгаа. Тэгэхээр бид нар энийгээ хэрэгжүүлэх чиглэл дээр болбол энэ төсвийн тухай хууль болоод Аудитын тухай хууль дээр зарим асуудлаар судалгаа хийж, саналаа бол бас саяын таны хэлсэнчлэн дараагийн тэр ажлын хэсэг дээр танилцуулаад, ингээд цаашаа боловсронгуй болох явчих ийм бололцоо бас бидэнд гарах байх гэж бодож байгаа.

Хуучин болбол бас энэ аймгуудын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар энэ тэр дээр манай тавьсан актыг энэ тэр бас шийтгэх хуудас бичээд ингээд хэрэгжүүлээд

ингээд үр дүнтэй явж байсан ийм хамтын ажиллагаа байсан юм билээ. Тэгээд одоо болбол одоо манайх болбол байцаагчийн эрхгүй ийм байгууллага учраас манай энэ актуудыг болбол шууд биелүүлэхээс бол биелэлтийг хангах дээр бол бас ажиллах ажиллахгүй байх ийм ажиллахгүй байгаа ер нь үндсэндээ. Тэгээд тэд нар ч бас тийм үүрэг хүлээхгүй байгаа гэдгээ бол тайлбарлаж байгаа. Тийм учраас энэ чиглэл дээр бид нар гарц гаргалгаа олж, намрын чуулган гэхэд бол энийгээ боловсронгуй болгоно гэж ингэж тооцож байгаа. Хэрвээ ингээд энэ чиглэлээр хамтраад ажиллаад эхлэх юм болбол аудитын шийдвэрийн хэрэгжилт бол бүрэн биелэгдэх бололцоотой.

Нэг онцгойлон анхаарах зүйл бол манай завсрын аудит 8 сараас эхэлнэ. Энэ үед болбол манай энэ завсрын аудиттай байгууллагууд хамтарч ажиллаад, завсрын аудитаар өгч байгаа зөвлөмж чиглэлүүдийг онцгойлон анхаараад явах юм болбол одоо заавал аудитаас тэгж том том шийдвэрүүд гараад байх шаардлагагүйгээр шаардлага байхгүй болох юм байгаа юм. Тийм учраас энэ завсрын аудитад одоо би байгууллагуудыг онцгойлон анхаараасай гэж хүсэж байгаа. Энэ чиглэлээрээ бол бид нар бас байгууллагуудтайгаа хамтарч ажиллана аа. Бичиг сачгаа өгөөд бас хамтарч ажиллах бололцоо бас бүрдэх байх аа. Заавал зөрчлийг гарсан хойно нь биш гараагүй байхад нь бол одоо бас яах боломж байгаа л гэж харж байгаа.

Д.Батбаяр: Батжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Батжаргал: Тийм. Саяын асуулт бол би аудит руугаа хандсан асуулт биш байсан юм. Бид нэгэнтээ л энэ санхүүгийн программ нэвтрүүлээд л явж байгаа юм бол энэ зардлын гүйлгээнүүд ямархуу байдлаар хүсэлт нь шивэгдэж, зардал нь гардаг байх вэ гэдэг асуудлыг энэ программ талдаа суулгамаар байгаа юм. Энэ чинь дийлэнх асуудал бүрдэл хангагдаагүй материалаар гүйлгээ гарчхаад байгаатай холбоотой юм байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо энэ алдаанууд дээрээсээ хараад ийм бүрдэл хангагдаагүй материал тэр программ нь уншдаггүй, зардлын гүйлгээ хийдэггүй л болгочих юм бол болж л байгаа байхгүй юу. Энийг нэгэнтээ л хүний оролцоогүй л асуудал шийдье л гээд байгаа бол. Тэгэхээр энүүнийг би Сангийн яамыг анхаараасай. Энэ дээр ер нь ямар бодол санаа байна вэ гэдэг нэг ийм зүйл. Яах вэ дээ бид үндсэндээ нэг тийм цахим засаглал руу явж байгаа нэртэй. Энэ нягтлангуудыг одоо үндсэндээ цаасан тайлангаас холдуулаад нэг программд шилжүүлчхээд байгаа нэг тийм хаашаа ч юм автомат ажиллагаатай ч юм шиг нэг ийм балай юм болгочхоод байгаа юм яг үнэнийг хэлэхэд.

Тэрнээс болоод энэ санхүүгийн ажилтнуудын чинь мэргэжлийн ур чадвар бараг л буурах хэлбэр лүүгээ яваад байгаа шүү. Би л лав мэдэхдээ одоо ер нь тэр шатар баланс энэ тэр хийдэг гарууд байна уу, үгүй юу энэ чинь ер нь. Энүүнийг л одоо хэдүүлээ нэгэнтээ л ийм байдал бий болгоод байгаа юм бол нөхдөг юмыг программдаа шигтгэх юмаа л бодох ёстой. Энийгээ л хийж чадвал энэ нэг яригдаад байгаа тоонууд чинь гарахгүй байх бололцоо нь бүрдэнэ. Хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр батлахгүй байна гэдгийг Их Хуралд сануулаад байгаа аудитын дүгнэлт. Ер нь би энүүнийг зөв гэж бодоод байгаа юм. Энэ угтаа баталж байж сая энэ хөрөнгө оруулалтын ажлуудын бэлтгэл хангагдах, тэгээд богино хугацаанд хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэл нь хангагдаж явах нөхцөл бүрдэх юм. Энэ гаднын улс орнууд чинь бол бэлтгэл ажил хангалт дээрээ нэлээн цаг хугацаагаа зарвал зарцуулж тодорхой дүгнэлт, судалгаа үнэлгээ хийж байгаад хөрөнгө тавигдлаа бол ажил маш богино хугацаанд бүтээн байгуулалт явчхаад байгаа байх...

Д.Батбаяр: Сангийн сайд хариулъя. Сангийн сайдын микрофоныг нээгээрэй.

Б.Жавхлан: Батжаргал гишүүнтэй санал нийлж байна аа. Тэр программ болон бид нар тэр нөгөө төрийн сангийн үйл ажиллагааны процессын асуудлыг яг хөндөж байна. Энэ дээр бид нар сайжруулалт хийх дээр онцгой анхаарч ажиллая аа. Мөнхсүх дарга бас нэмэлт юм байвал хариулаадхаарай.

Сүүлийн тэр хөрөнгө оруулалтын тэр дунд хугацааны хөтөлбөр төлөвлөгөө батлах бол маш чухал шүү Батжаргал гишүүн ээ. Одоо хэн Дэгий дарга юугаа бид нар сая өргөн барьж амжаагүй тиймээ Хөрөнгө оруулалтын хуулиа. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуультай хүмүүс андуурч яриад байдаг юм шүү. Одоо бид яг Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хууль бэлдсэн байгаа тусдаа. Тэрийг оруулж ирэхээр яг таны наад асуудал чинь яг хөндөгдөөд нэлээн өргөн сэдэв болж явах ёстой. Тэгэхээр өөрөөр хэлбэл тэр хөрөнгө оруулалтын тухай хууль дээр яг таны хэлсэн тэр бэлтгэл ажил төсөвлөх, хуульчлах, дараа нь гүйцэтгэл гээд энэ үе шатууд дээр ямар эх үүсвэрээр юуг барих юм, юуг барихгүй юм, юуг хөндөхгүй юм, төсвөөр одоо ер нь энэ зарцуулалтуудыг нь маш сайн одоо тодорхой хуульчилж өгөх ийм одоо хууль орж ирэх юм байгаа юм. Энэ манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ч гэсэн энийг одоо бидэнд шаардлага ирүүлсэн. Тэр дагуу энэ хууль одоо бэлтгэгдэж байгаа гэсэн үг.

Тэгэхээр энэ хууль бол цаашдаа маш чухал ийм одоо хууль болно оо. Тэгээд намар өргөн барих уу тэгье. За тэгье намар өргөн барих тиймээ.

Д.Батбаяр: Батжаргал гишүүн ахиж тодруулж асууна.

Ж.Батжаргал: Санал хэлж цаг аваад яах вэ. Одоо орж ирсэн энэ гүйцэтгэлээ батламжилъя энийг нь дэмжиж байна. Аудитынхаа өгсөн дүгнэлт зөвлөмж дээр тулгуурлаж Төсвийн байнгын хороо, Зарлагын хяналтын дэд хороо жоохон сууж хэдүүлээ энүүнийг Их Хурлын төсвийн хуулиуддаа тусгалыг нь олж оруулаад тэгээд хяналтаа сайжруулъя. Тэгж байж л нийтээрээ үр дүн гарна л гэж харж байна.

Д.Батбаяр: Батжаргал гишүүн асуулт асуулаа. Баярлалаа танд. Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууна.

Да.Цогтбаатар: Бид нар улсын төсөв үрэхдээ болбол мөнгө ургуулдаггүй. Энэ зөвхөн орлогын албан татвар, нийгмийн даатгал, нэмэгдсэн өртгийн албан татвар НДШ гээд ард иргэд буюу энэ ард иргэд эсвэл ААН-үүдээсээ төсвийнхөө бараг 70 орчим хувийг цуглуулаад хүчээр цуглуулж байгаад үрж байгаа мөнгө. Үрэхээ болохоор бид нар нэг 8 сарын 30-нд багтааж төсвийн төслөө өргөн бариад, тэгээд 14 хоног нийт иргэдийн хэлэлцүүлэг хийгээд гээд ингээд маш их хугацааг зарцуулдаг байж байж буцаагаад үржсэн мөнгөн дээр чинь нэг ийм ажил хийчихлээ шүү гэж тайлан тавихдаа одоо миний мэдэж байгаагаар өнгөрсөн жил 2024 онд 2023 оны асуудал орж ирэхдээ бас л нэг ийм төсвийн тодотголын үеэр шинэ Засгийн газар бүрэлдэж байгаа үеэр гээд ингээд иргэдийн анхаарлын төвөөс хол байлгаж байгаад ярьчихсан. Энэ жил бас л яг тэр алдаа давтагдаж байна гэж би бол харах гээд байгаа юм.

Тэгэхээр ядахдаа энийг чинь нэг иргэдэд нээлттэй мэдээлэл түгээдэг. Одоо энэ 2025 онд 33.5 их наядын төсөв батлахдаа бид нар энэ баталсан төсвөөр ийм юм хум хийчихлээ, ийм алдаа дутагдал гаргачихлаа, энэ дээр ийм хариуцлага хүлээчихлээ одоо энэ дээр яах вэ гээд ингээд иргэдийнхээ санал хүсэлтийг тусгадаг

байдлаар явахгүй болбол үр ашиггүй байдал гэдэг чинь маш ихээр яригдаад байгаа юм. 122 их наяд төгрөгийн нийт хөрөнгө одоо энэ Монгол Улсын төр засагтай холбоотой эргэлдэж байгаагаас 15.7 их наяд дээр нь алдаа дутагдал гарч байгаа юм. Малын хулгайч зайлуул үсрээд л нэг хурдан удмын адуу, 100 саяын адуу хулгай хийлээ гэхэд шууд эрүүгийн хариуцлага. Өнчин ишиг хулгай хийлээ гээд дахиад л эрүүгийн хариуцлага. 15 их наядын хулгайн алдаа дутагдал зөрчил гарчхаад байхад хариуцлагын асуудал одоо яригдах нь чухал. Тэгэхдээ хэзээ юм бүү мэд, сайд нарынх нь байж байгаа царай. Одоо нэг ч сайд нь байхгүй. Сангийн сайд л энэчээ нэг үйлийн үртэй юм шиг асуугдаад л хоцорч байгаа юм.

Төсвийн ерөнхийлөн захирагч нар гээд энэчээ чинь мөнгө үрж байгаа маш олон албан тушаалтан байж байж нэг нь ч орж ирж хариуцлагатай, өнгөрсөн жил ийм мөнгө ингээд үрчихсэн, одоо энэ дээр ямар алдаа дутагдал гарсан бид нар ямар хариуцлага хүлээх вэ гэдэг юм байхгүй. Сайд нартай нь ярихаар бид нарт хамаагүй тэр доод байгаа, одоо байгууллагууд нь хариуцлага хүлээдэг юм байна лээ гээд байгаа юм. Хариуцлага хүлээлгэж чаддаггүй юм бол ер нь сайд болоод ч яадаг юм. Бид нар мөнгө үрэхдээ үнэхээр хариуцлагагүй. Одоо хамгийн сүүлийн жишээ нүдэн дээр ил харагдаж байгаа шүү дээ. Явган хүний замын зүв зүгээр байгаа чулууг хуулаад л буцаагаад солиод байгаа юм. Иргэд нийслэлийн иргэдийн хурал эсвэл нийслэлийн удирдлагууд. Тэгтэл нийслэлийн дарга нарт тансаглуулахын төлөө нийслэлийн нэг хурган дарга Ланд 300 гэдэг машин уначихсан явж байгаа юм. Хамгийн үнэтэй микро автобусыг нийслэлийнхэн унаж байгаа юм. Тэгээд нийслэлийнхэн болбол нийслэлийн хэдэн дарга нарыг тансаглуулахын төлөө мөнгөө төлдөг, буцаагаад нийслэлийн төсвийг юунд зарцуулчихсан юм, яачихсан ийчихсэн энэ тайланг нь сонсьё гэхээр бас хэн ч байхгүй.

Тэгээд энэ аудитын дүгнэлттэй холбоотой аудитынхнаас энэ гаргасан дүгнэлтээ яг дэлгэрэнгүйгээр нь өгөөч гэсэн бас ирээгүй байгаа. Одоо энэ 15.7 их наяд төгрөг нэг төгрөг бүрийнх нь хариуцлагыг ярьж гэхээр бас ирээгүй байгаа. Нэг минут.

Д.Батбаяр: Цогтбаатар гишүүн гүйцээж асууя. Нэг минут.

Да.Цогтбаатар: Тэгээд 2024 онд чинь болбол өөрөө их онцлогтой он байсан шүү дээ. Сонгуулийн жил байсан. Сүүлийн 8 жил нэг нам дангаараа засаг барьсан. Тэгээд одоо энэ хариуцлагын асуудал ингээд л яригдаад яригдаж чадахгүйгээр хоцордог гэдэг чинь угаасаа одоо энэ МАН-ын удирдлага, тэдгээрийн ах дүү, хамаатан садан, одоо сүүлдээ бүүр үеэл хаяалаараа төрөөс төрсөн тэрбумтангуудын тод жишээ болж үлдэж байгаа. Бүгдээрээ энэ түгжрэл дунд ч байхгүй, уулын аманд нэг нэгээрээ амьдарч байгаа. Шаардлагатай бол би нэр устай нь сайхан зарлаж байгаад ярьж болно. Цаг нь ирэхээр. Тэгээд сая энэ Сангийн сайд бас ярьсан. Нөгөө инженер одоо энэ зөвхөн эрчим хүчний салбарт ярихад инженер техникийн ажил чинь 30 хувийг нь эзэлж байгаа юм. 70 хувь нь бусад ажилчид байгаа юм. Тэгээд яг нөгөө нисдэг, нисдэггүй бор морины үлгэрээр төрийн албан хаагч гээд ажил хийж байгаа зөв хүмүүсээ үлдээгээд, ажил хийдэггүй тэр бусад захиргааны шинж чанартай ажлуудыг цомхотгоод, үр дүнтэй, үр ашигтай төрийн албан хаагчийг гаргаатахаач гэхээр юу ч гарч ирж чаддаггүй. Сангийн сайдад, Сангийн яаманд буруу мэдээлэл бид нар танаж байна, хасаж байна гээд...

Д.Батбаяр: Тийм хариуцлагын асуудал дахиад л яригдаад байгаа юм. Гүйцэтгэл гээд хэлэлцээд явахаар бид нар бүгдээрээ л хариуцлагын асуудал яригдаж байгаа юм. Хариуцлага тооцдог уу, тооцдоггүй юу гээд сая асуулт асуусан.

Гишүүн болгон л ер нь асуулаа шүү дээ. Бизнесийн байгууллагууд дээр хариуцлага ярих болохоороо тэр дороо хэрэгжчихдэг, дансыг нь хаачихдаг, торгууль тавигдчихдаг, иргэнд чиглэсэн захиргааны актууд нь дороо хэрэгждэг, бараг 90-ээс дээш хувьтай хэрэгжиж байгаа шүү дээ. Тэгвэл яг энэ төсвийн захиран зарцуулж байгаа, төвлөрүүлэн захируулж, зарцуулж байгаа энэ албан тушаалтнуудад ер нь ямар хариуцлага оногдож байгаа юм бэ? Ноогдуулсан юм бэ бодит байдал дээр юу байгаа юм бэ гэдгийг дахин дахин асуугаад байна. Тэгээд аудитын байгууллагуудаас өөрийнхөө хэмжээгээр хариулаад байх шиг байна.

Энэ удаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүйн яамнаас мөн прокурорын байгууллагуудаас асуулт асуучихмаар байна. 9 номерын микрофон дээр сууж байгаад. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас төлөөлөл байгаа билүү? Ирц чинь хаа байна? Бямбацогт сайдыг орлож байгаа хүн хаа байна? Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүйн яам, прокурорын байгууллага. Та 9 номер дээр суучих. Тэгээд өөрийгөө танилцуулаад албан тушаалаа хэлээд 9 номерын микрофоныг нээе.

Н.Мягмар: Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар. Буруутай албан тушаалтнуудад хариуцлага хүлээх асуудал болбол мэдээж төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан гэдэг юм уу, төсвийн хөрөнгийг шамшигдуулсан гэдэг юм уу энэ асуудал хэрвээ илрүүлбэл хууль хяналтын байгууллагад тухайн төрийн байгууллагаас хүсэлтээ гаргаад хянан шалгуулах бүрэн бололцоотой байгаа. Эрүүгийн хууль болоод бусад хуулиар болбол төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан гэдэг эрүүгийн хуулийн гэмт хэргийн байгууллагаар болбол хянан шалгах ийм бүрэн бололцоотой байж байгаа. Бусад асуудал дээр болбол аудитын байгууллагын болон бусад одоо албан тушаалтнуудын өгсөн тайлбартаа болбол санал нэг байна. Мэдээж хэрэг одоо улс төрийн хариуцлага хүлээгээд явчихсан улсууд дээр хэрвээ энэ одоо төсвийн хөрөнгийг шамшигдуулсан, зориулалт бусаар ашигласан, авлига албан тушаалын шинжтэй ийм үйлдлүүд гаргасан болбол эрүүгийн хууль тогтоомжоороо болбол шалгуулах бүрэн бололцоотой байж байгаа гэдгийг хэлье.

Д.Батбаяр: Үг байгаа. Пүрэвдаваа гишүүн асуулт асууя.

Д.Пүрэвдаваа: Өглөөний мэнд хүргэе ээ. Энэ Зарлагын хяналтын дэд хороо гэдэг бол сөрөг хүчнээс дарга нь тавигддаг ийм учиртай хороо юм байгаа юмаа. Тэгээд ялангуяа энэ 42 суудалтай АН бол эндээ маш идэвхтэй оролцож, байр сууриа илэрхийлж, дээрээс нь энэ ирээдүй болох энэ 2025 оны гүйцэтгэл дээр дахиж алдааг давтахгүй байх тал дээр үр өгөөжтэй тийм хурлыг зохион байгуулах ёстой гэж харж байгаа. Тэгээд би энэ нэг өнөөдөр бол ингээд олон хоног давтаад л энэ асуудал яригдаад байгаа учраас энэ Засгийн газарт өгсөн аудитын тайлан дүгнэлтийн 17 дугаар хуудсан дээр энэ том дүнгүүдтэй юмнуудыг нь л нэг асуучихъя гэж бодоод байгаа юм. Батлагдсан төсвийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан нийт 33.8 тэрбум төгрөг тэгээд энэ ГХС гэхээр Гадаад хэргийн сайд юм уу даа. 8 тэрбум уу? Энэ нь ямар улсууд, ямар зөрчил гаргаад ингээд 33.8 болчихсон юм. Нэг жишээ татаадхаач.

За 2 дахь нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон гэрээний заалтыг зөрчсөн, биелэлт хангалтгүй, гэрээ байгуулаагүй байхад зардал гаргасан зэрэг нийт 161.6 тэрбум төгрөг тэгээд хаалтан дотор СС 73.6, МУШС 33.8 гээд энэ одоо энэ төсвийн ерөнхийлөн захирагч нар юм шиг байна. Энэ одоо 161 тэрбум төгрөг гэдэг чинь маш

их мөнгө шүү дээ. Тэгээд нөгөө аудитынхан маань энэ хэмнэлтийн тухай хууль 5 сарын 31-нээс өмнө бүгд л гэрээ хийчихсэн тэгээд нөгөө хэмнэлтэд хамрагдаагүй 31-нээс хойш гэрээ хийж амжаагүйнүүд нь ингээд хэмнэлтэд хамрагдчихдаг. Энэ дээр болохоор 161-ийн одоо 2024 онд бол зөрчил гарчихсан байна шүү дээ. Одоо тэгээд энэ жишээгээр энэ 2025 оны 5 сарын 31-нээс гэрээ хийсэн гэж нэрлэгдэж байгаа нөхдүүд дээр одоо яаж хянадаг юм бол доо. Тэр нэг ийм бас нэг дэс дараалал байдаг юм болов уу? Одоо тодотгол орж байгаатай холбогдуулаад бас нэг асуучихъя.

За тэгэнгүүт энэ 150 тэрбум төгрөг байна. Батлагдсан төсвөөс харьяа байгууллагын зардлыг санхүүжүүлсэн 151.3 тэрбум төгрөг байна. Энэ чинь бас аймаар дүн шүү дээ. За нэг ийм юм байна. За тэгэнгүүтээ 36 дугаар хуудас байсан байх аа. Энэ дээр нэг тэр Тавантолгойн ноогдол ашгийг хуваарилаагүй зөрчил гээд нэг юм биччихсэн байсан. 108 тэрбум төгрөг. Тэрийг нь тэгээд компанийн захирал нь өөрөө ингээд дур мэдээд бариад...

Д.Батбаяр: Пүрэвдаваа гишүүн дахиад нэг минут нэмье.

Д.Пүрэвдаваа: Тийм тэр нэг компанийн ноогдол ашгийг хуваарилах ёстой юм байна аа гэж ойлгосон. Тэгсэн чинь ноогдол ашгийг нь ЭТТ компанийн 108.7 тэрбум төгрөгийн ноогдол ашгийг тараагаагүй байгаа нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт хохирол учруулж, Компанийн тухай хуульд хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчинд нийцэхгүй нөхцөл үүсчээ гэж байгаа юм. Энэ чинь урьдчилж төлөөлж эргэлдүүлж байна аа гэж ойлгож болох уу? Тэгээд Шилэн дансны хуулийг дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний үр дүнгээр Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна аа гэж дүгнэсэн байна. Тэгээд энэ Шилэн дансны хууль чинь одоо маш олон жил тогтвортой явж байгаа. Энэ хэрэгжүүлэхгүй байгаануудын нэрсийг нь хэвлэж ингээд олон нийтэд нийтэлж болдог уу? Дараа нь тодруулъя.

Д.Батбаяр: Аудитын дүгнэлттэй холбоотой асуултууд байгаа учраас эхлээд Магнайсүрэн дарга та бүгдэд нь энэ энэ байгууллагууд аудитын байгууллагаас ийм ийм учиртай гээд бүх байгууллагууд нь зарлачих. Дараа нь холбогдох байгууллагууд нь тайлбараа хийгээд явах нь зүйтэй байна. Аудитын байгууллагын 6 номерын микрофоныг нээе.

Ц.Наранчимэг: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байгаа. Бид Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд 6832 төсөв захирагчийн тайланд аудит хийгээд, тэр аудитаар гарсан одоо алдаа зөрчлүүдийг нэгтгэсэн тайланг Улсын Их Хуралд хүргүүлэх ийм үүрэгтэй. Тэгэхээр энэ 6832 төсөв захирагчийн гаргасан алдаа зөрчлүүдийг нэгтгэж, энэ тайланд тайлагнасан байгаа. Жишээлбэл Гадаад харилцааны сайдын багцад байгаа энэ зөрчлүүд дээр Гадаад харилцааны сайдын нийт төсвийн 75.9 хувийг дипломат төлөөлөгчийн газруудын төсөв бол эзэлж байгаа. Эдгээр бол төсвийн шууд захирагч байгаа. Мөн төрийн өмчит компани байгаа. Эдгээрүүдээс гарсан энэ зөрчлүүдийг нэгтгэж ингэж гаргасан байгаа. Байгууллага нэг бүрээр нь хэлнэ гэх юм бол маш олон байгууллагыг хэлэх гэж байна. Энэ ХАА Пүрэвдаваа гишүүнд би задаргаагаар нь хүргүүлчихвэл...

Д.Батбаяр: Бишээ, ингэхгүй шүү. Юу яана аа Наранчимэг дарга аа. Сая танаас 3 тоо л асуулаа шүү дээ. тэр 3 тоон дээр ядаж хариулчихъя л даа. 161 тэрбум, 150 тэрбум, эхнийх нь хэд байлаа.

Ц.Наранчимэг: Тийм 33.8.

Д.Батбаяр: 33.8 тийм, дараа нь хүргүүлнэ гэдэг байдлаар явмааргүй байна. Одоо шууд та хариулчих.

Ц.Наранчимэг: Одоо нөгөө байгууллага нэг бүрээр нь гэх юм бол над дээр нэгтгэл тоо нь байгаад байна л даа. Тэгэхээр нөгөө төсвийн шууд захирагчуудынхаа бүх тайлангуудыг үзэж байж энэ чинь нэгтгэл тайлан учраас тэрийг гаргаж авч байж дүнгийн нь одоо байгууллагуудын нэрсийг хэлнэ. За энэ дээр энэ зориулалт бусаар зарцуулсан гэдэг дээр төсвийн тухай хуулийн 70.3 дээр заавал төрийн аудитын байгууллагаас хариуцлага тооц гэдэг энэ албан шаардлагыг авахгүйгээр төсвийн тухай хууль дээр зориулалт бусаар үр ашиггүй зарцуулсан байвал одоо тэр төсөв захирагчийг ажлаас чөлөөлөх үндэслэл болно гээд заачихсан учраас энэ одоо бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нар бол өөрсдөө аудитын байгууллагаас ирсэн одоо тайланд дүгнэлт хийгээд, тэгээд энэ дээр хариуцлага тооцох энэ үндэслэл нь бол хуулийн үндэслэл нь бол байж байгаа.

За төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдаж авах энэ хуулийн хэрэгжилтийн гэрээ зөрчсөн энэ байдал бол бас нэлээн хангалтгүй байгаа. Энэ дээр бол 161.3 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн. СС гэдэг нь бол Сангийн сайд байгаа. За Сангийн сайдын энэ зөрчил бол Сангийн сайдын тайланд төсөл хөтөлбөрийн нэгжүүд нэгтгэгдэж байгаа. Тэгэхээр энэ төсөл хөтөлбөрийн нэгжүүд дээр байгаа энэ худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлыг түрүүний нэгдсэн чуулган дээр Монгол Улсын ерөнхий аудитор хариулсан. Гэрээгээ хийхдээ гэрээндээ эндээ одоо аль хуулийг нь мөрдөх юм бэ? Одоо энэ олон улсын эрх зүйн энэ конвенцоо мөрдөх юм уу?...

Д.Батбаяр: 6 номерын микрофон Наранчимэг дарга гүйцээж хариулъя.

Ц.Наранчимэг: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн заалтыг мөрдөх юм уу гэдгийг тодорхой зааж өгөөгүйгээс энэ асуудал байгаа гэдгийг одоо бас хэлсэн байгаа. Тэгээд энэ бүх сайд нарын дандаа нөгөө харьяа байгууллагууд дээр нь гарсан энэ зөрчлүүдийг нэгтгэсэн тайлан учраас энэ зөрчлүүд маань нэгтгэгдэж байгаад Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан дээр хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл болж ингэж гарч байгаа гэдгийг одоо хэлье ээ гэж ингэж бодож байна.

Энэ ноогдол ашгийн асуудал бол төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиараа ноогдол ашгийн асуудлыг ТӨБЗГ бол хариуцаж байгаа. За ноогдол ашиг болбол одоо төлөх асуудал нь бол хууль болж, орлого талдаа батлагдаж байгаа. Тэгэхээр ноогдол ашгаа хугацаанд нь төлөхгүй байгаа асуудал дээр төрийн аудитын байгууллага аудит хийхдээ энэ дээр ноогдол ашгаа барагдуулдаг бас төлбөрийн акт тогтоох ийм асуудал яригдаад ингээд явж байгаа.

Д.Батбаяр: За байж байгаарай. Гадаад харилцааны яам Мөнхтүшиг дарга байгаа тиймээ. 8 номерын микрофон нээе.

Л.Мөнхтүшиг: Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхтүшиг. Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж дүгнэлттэй холбоотой сая гишүүний дурдсан тоон дээр бас залруулга хиймээр байна аа. ГХЯ 8 тэрбумын зөрчил гаргасан гэдэг байдлаар

яасан. Би бас аудит манай байгууллага бас аудитын байгууллагатай яриад энэ тоогоо тулгаад 1 дүгээрт бол 5 тэрбумын асуудал байгаа. Гэхдээ энэ үнэ нь их, бага гэдэгтэй биш энэ дээр тайлбар хэлье. Аудитын байгууллагаас өгсөн дүгнэлтээр ГХЯ 2024 оны төсвийн гүйцэтгэл өөрчлөлтгүй. Дипломат төлөөлөгчийн газар дээр бол хязгаарлалттай гэсэн ийм зөвлөмж гарсан. 5 тэрбум дээр ямар асуудал байгаа вэ гэхээр 50 гаруй хувийг нь буюу одоо энэ 2.5 тэрбум төгрөгийн асуудал нь он дамнадаг буюу одоо 1 дүгээр сарын 20-доор болдог Дэлхийн эдийн засгийн чуулган одоо Давосын эдийн засгийн чуулга уулзалт гэж ярьдаг. Энэний төсөв нь он дамнаад тайлагначихсан асуудал орсон байгаа. Энийг бид хэрэглэ...

Д.Батбаяр: 8 номерын микрофон гүйцээж хариулна аа.

Л.Мөнхтүшиг: Тийм, тэгээд энэ болбол яг он дамнаад тайлагначихсан. Монгол Улсын Ерөнхий сайд одоо тодорхой шалтгааны улмаас оролцож бол оролцоогүйтэй холбоотойгоор энэ төсөв хэмнэгдсэн гэж үзэж болно. Төсөвт хувь хувиараа буцаад хураалгасан гэсэн үг тийм. Нөгөө 2015 онд манай Гадаад харилцааны сайдын багцад 6 байгууллага тайлагнадаг. Яг гадаад харилцааны төв аппарат дээр 67 сая төгрөгийн асуудал байгаа. Энэ дээр бид нар аудитаас өгсөн дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлээд явж байна. Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар СОР 17 гээд ялангуяа СОР 17 болбол өнгөрсөн оны 3 дугаар улиралд байгуулагдсан. Төсөв нь төсөвлөгдсөн боловч үйл ажиллагааны хувьд бол нэг улирал ажилласан учраас төсөв нь үндсэндээ ингээд танагдсан ийм асуудал гарсан гэдгийг хэлье.

Д.Батбаяр: Сангийн сайд Засгийн газрын хуралдаанд оролцож байгаа, оролцохоор гарсан байгаа. Тэгэхээр Сангийн яамыг төлөөлж хариулах хүн маань. Дэлгэржаргал дарга 9 номерын микрофон дээр суучих.

Ж.Дэлгэржаргал: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар Дэлгэржаргал. Тэгэхээр аудитын тайлан дээр байгаа Сангийн сайдын 73 тэрбумтай холбоотой асуудал бол олон улсын түншүүдийн хүрээнд хийж байгаа гадаадын зээл тусламжийн төслүүдийн асуудал байгаа. Сангийн сайдын багц дээр тайлан нэгтгэгддэг. Хэрэгжүүлэгч байгууллагууд нь бол тухайн яамдууд байгаа. Тэгэхээр энэ дээр гарсан асуудал бол одоо Солонгосын Эксим банкны зээлээр хэрэгжиж байгаа төсөл бол Солонгосын Эксим банк. Хэлэлцээр нь УИХ-аар батлагдахдаа Солонгосын Эксим банкны худалдан авах ажиллагааны журмаар Азийн хөгжлийн банк, Азийн хөгжлийн банкны худалдан авах ажиллагааны журмаар Дэлхийн банкных, Дэлхийн банкны худалдан авах ажиллагааны журмаар гээд ингээд хэлэлцээр нь батлагдчихсан учраас яг худалдан авах ажиллагаа тендер зохион байгуулалт нь хөгжлийн түнш байгууллагынхаа дүрмээр явдаг. Тэгэхээр аудитын тайлан дээр ялангуяа гадаад зээл тусламжийн төслүүд дээр 2 талын хяналт хийгдээд явдаг. Хөгжлийн түнш байгууллагууд нь улирал тутам хяналт хийгээд зөвлөмжөө өгөөд явдаг...

Д.Батбаяр: 9 номерын микрофоныг нээе гүйцээж хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Монгол талаас бас яг дотоодын хяналт шалгалтын хууль дүрмээрээ бид нар хяналт хийгээд явдаг. Тэгэхээр энэ аудитын тайлан дээр дүгнэгдсэн асуудал бол дотоодын тендерийн хуулийг мөрдөх асуудлыг дурдсан байгаа. Тэгэхээр бид нар бол энэ дээр хангалттай тайлбар мэдээллүүдийг өгсөн. УИХ-аар батлагдсан хэлэлцээр нь өөрөө хөгжлийн түнш байгууллагын дүрмээр

явна гэсэн дээр бид нар одоо Худалдан авах ажиллагааны хуулийг мөрд гэдгийг бол Сангийн яаманд энийг тэгж одоо зохицуулах боломжгүй асуудал байгаа.

Д.Батбаяр: Төрийн өмчийн хорооноос байгаа билүү? Цэнгэл дарга байгаа билүү? та 9 номерын микрофон дээр суучих уу?

Б.Цэнгэл: Ноогдол ашигтай холбоотой асуудалд хариулт өгье. Гишүүний асуултад хариулъя. 2024 онд бид нар 596 тэрбум төгрөгийн ноогдол ашгийг төвлөрүүлсэн байж байгаа. Энэ бол нөгөө Ирээдүй өв санал руугаа бол ер нь голлон орсон байж байгаа. Гишүүний ярьж байгаа тэр Тавантолгойн ноогдол ашиг бол нөгөө төрд оногдох төрд оногдож байгаа ногдол ашиг нь бол үндсэндээ бол 3 тэрбум байгаа. Энэ 3 тэрбумыг одоо яаж зарцуулах вэ гэдэг асуудлыг бол хувьцаа эзэмшигч болон ТУЗ-ийнхөө хурлаар бол Тавантолгойн энд хэлэлцэх одоо ийм шаардлагатай байгаад байгаа юм. Энэ дээр бол бас хэд хэдэн хувилбарууд руу яригдаж байгаа. Тухайлбал төмөр замын төсөлд оруулсан хөрөнгийг одоо яах вэ гэж байгаа. Тухайлбал төмөр замын төсөлд бол 1.3 их наяд орчихсон байж байгаа. Энэ бол мөнгө нь бол ЭТТ-гоос гаргасан байх. Засгийн газрын шийдвэр гаргаад бол Тавантолгой энэ хөрөнгийнхөө асуудлыг шийд гэсэн. Тэгээд энэ дээр бол одоо тодорхой хэмжээний...

Д.Батбаяр: Цэнгэл даргын 9 номерын микрофоныг нээе. Гүйцээж хариулъя.

Б.Цэнгэл: Төрд оногдож байгаа ноогдол ашгаар нь одоо суутган тооцох ийм хувилбарууд ярьж байгаа. Тэгэхээр энийг бол ойрын хугацаанд бол ЭТТ-н хувьцаа эзэмшигч буюу одоо хувьцаа эзэмшигчдийн хэрэгжүүлэгчид одоо энэ асуудлаа яаралтай ТУЗ-аар оруулаад шийдвэрлэх шаардлага байж байгаа. Зүгээр 600 орчим тэрбум төгрөгийг бол төвлөрүүлсэн байж байгаа тийм.

Д.Батбаяр: Пүрэвдаваа гишүүн тодруулж асууя.

Д.Пүрэвдаваа: Ийм байхгүй юу даа. Энэ 2024 оны гүйцэтгэл шүү дээ. Одоо чинь 2025 оны 7 сар. Тэгээд та бүхэн маань ингээд нэг яг одоо өрнөж байгаа юм шиг юмаа яриад байгаа байхгүй юу. Энэ чинь аль хэзээний шийдвэрлэгдээд ялангуяа та бүхэн маань Төрийн албаны тухай хуульд юу гэж заасан бэ гэхээр зэрэг хууль дээдэлнэ ээ л гэж байгаа шүү дээ. Тэгээд тэр хууль дээдэлж байгаа юм нь бол ердөөсөө ажиглагдахгүй. Тэгээд энэ чинь хагас жилийн хугацаанд ингээд бүр орхигдоод хаяад эсвэл нэг амарч байгаад ирсэн хүмүүс шиг хариулаад байна шүү дээ.

Магнайсүрэн даргад би нэг ийм сайн одоо шинээр томилогдсон өмнө нь гаргасан дүгнэлтүүдийг бодвол маш тодорхой оновчтой дүгнэлт гаргасанд талархаж байна. Цаашдаа улам энэ улс төрөөс хараат бус дүгнэлтүүдийг, шийдвэрүүдийг гаргаж яваарай гэж...

Д.Батбаяр: Санал байлаа. Одоо Бейсен гишүүн асууна аа. Бейсен гишүүний микрофоныг.

Б.Бейсен: Та бүгдэд өглөөний мэнд хүргэе. Би 2 асуудал асуух гэсэн юм. Нэгдүгээрт, эрүүл мэндийн салбарын өр зээлтэй холбоотой асуудал. Энэ он дамжсан өр зээл байх юм. Энэ аудитын газар үнэхээр энэ дээр нарийвчлан дүгнэлт хийсэн юм болов уу. Яагаад гэвэл одоо ЭМД-ын сангийн одоо буруутай үйл ажиллагаа байна уу, аль эсвэл төсвийн захирагчдын одоо орон тоог хэтрүүлсэн ч

юм уу, буруу зарцуулсан ч юм уу энэнтэй холбоотой байна уу. Он дамжсан өр одоо гарч ирээд одоогийн эхний 6 сарын байдлаар бүр нэлээн хэтэрлээ. Хотын клиникийн эмнэлгүүд, хөдөөгийн аймгуудын нэгдсэн эмнэлгүүд, дүүргийн эмнэлгүүдийн өр зээл гээд одоо хэрээс хэтэрч байна. Энэ ЭМД-ын үндсэн зөвлөлийн буруу шийдвэрээс болсон уу, энэ талаар одоо нарийвчлан судалгаа хийсэн үү? Урьдчилсан байдлаар нэг аймагт одоогийн байдлаар 3 тэрбум орчим өртэй, НДШ ч өртэй, татвар ч өртэй, эмийн ч өртэй болчихоод эмнэлгийн тусламж цалгардаж байна. Гаднаас эм авчирч өвчлөөд хэвтэж байна.

Тэгэхээр энэ нарийвчлан судалгаа хийсэн үү? Энэ нарийвчлан судалгаа хийхгүй бол жилийн эцсээр энэ дүн чинь нэлээн өсөж гарах хандлагатай байна шүү. Энэ дээр судалгаа хийсэн үү нэгдүгээр асуудал байна.

2 дахь асуудал Баян-Өлгий аймгийн оношилгооны төв гээд 100 ортой Морин сувд констракшн барьсан эмнэлэг байгаа. Ашиглалтад өгөх ёстой байсан чинь одоо тэгээд л Сангийн яамныхан одоо Барилгын хөгжлийн төвийн 3 удаагийн дүгнэлт гарсан. Дахиад одоо аудитаар нарийвчлан хяналт шалгалт хийлгэнэ гэсэн байна. Гэтэл энэний цаана одоо алслагдсан аймгийн эмнэлгийн тусламж үйлчилгээ цалгардаж байгаа асуудал үүсэж байна. Энийг аудитын байгууллага шалгасан юм уу? Одоо ингээд 2026 он руу шилжих гээд байна шүү дээ. 2024 оны сүүлээр одоо хүлээлгэж өгөх ёстой байсан. 150 ортой болгоод барьсан байна тэр эмнэлгийг нь.

Тэгэхээр энэ дээр нэг анхаарахгүй бол энэний юун дээр чинь бид нар нарийвчлан бас аймгаас гарсан төлөөлөгч нь шалгаад үзсэн. Хагалгааны өрөөний 2 өрөөний блокийн асуудал яаралтай бол төлөвлөгөөт хагалгааны. Тэгээд хагалгааны дараах хүчилтөрөгчийн одоо систем, яаралтай тусламжийн хүчилтөрөгчийн систем, сэхээний тасгийн хүчилтөрөгчийн систем, хагалгааны дотор талын юуны тоног төхөөрөмжтэй холбоотой ингээд юу өссөн гээд ярьж байгаа. Нөгөө талаар хамгийн гол нь цалингийн зөрүүгийн асуудал байгаа юм байна. Энэтэй холбоотой энийг одоо шийдэж өгөх боломж байдаггүй юм уу?

Замын асуудлыг тавьж байна. Замаасаа түрүүн эрүүл мэндийн асуудал чухал байна шүү дээ. Энийг шийдчих боломж байдаггүй юм уу? Энэ дээр одоо аудитын байгууллага шалгалт хийсэн юм уу, үгүй юм уу? Сая одоо яамдуудаас бас гарч байна шүү дээ. Хэдэн тэрбумаар нь одоо ийм юм гарч байхад тэгээд нэг 3.7 тэрбум юм байна. Энийг шийдээд яачихгүй бол баруун аймагт одоо жуулчид очиж байна. 30-40 мянган жуулчид очиж байна. Алслагдсан улсууд нэг минут нэмээд авчихъя тэгэх үү Батбаяр дарга нэг минут нэмээд.

Д.Батбаяр: Бейсен гишүүнд нэг минут нэмж өгье.

Б.Бейсен: Тэгээд л энэ баруун аймгаас ирж байгаа харвалттай, гэмтэлтэй зүрхний шигдээстэй хүнд өвчтөнүүд тэгээд газраар гарч байна. Зарим нь замдаа одоо амь алдчихаад байна. Хот руу хүрч чадахгүй байна. Энийг шийдчихвэл тэгээд хотын эмч нар тэр орон нутагт нь тусламж үзүүлэх боломж байгаа байхгүй юу. Энэ дээр одоо нарийвчлан судалгаа гаргасан уу? Аудитын байгууллага тэгээд Сангийн яам нь үнэхээр тэр одоо хүсэлт гаргасан юм уу? 3 удаа дүгнэлт гарсан байна. Энэ дээрээ шалгасан уу? Тэрийг асуух гэсэн юм.

Д.Батбаяр: Маш тодорхой асуулт асуулаа шүү дээ Бейсен гишүүн. Яг энэ чинь Зарлагын хяналтын дэд хорооны яг жинхэнэ яг ийм л асуудал хэлэлцэж байх ёстой. Тэгэхээр тайлантай холбоотой асуудлыг Үндэсний аудитын газрын дарга

хариулаад дараа нь ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бас хариулах ёстой шүү. 5 номерын микрофон.

С.Магнайсүрэн: Бейсен гишүүний асуултад би энэ эмнэлгийн барилгатай холбоотой асуудлыг нь хариулчихъя. Яг он дамнасан өртэй холбоотой асуудлыг нь манай Наранчимэг дарга тодруулаад хэлчихэг. Барилгатай холбоотой асуудал бол нэг ийм асуудал сүүлийн үед манай дээр ч их ирж байна. Барилгын хөрөнгө оруулалт, зураг, төсвийн энэ магадлалтай холбоотой асуудлыг одоо манай байгууллагаар магадлал төсвийн өөрчлөлтийг магадлаач ээ гэдэг ийм асуудал их ирж байгаа юм. Уг нь бол Барилгын тухай хуульд заасны дагуу болбол Барилгын сайд, Сангийн сайд 2 хамтраад оны одоо үнийн өсөлтийн индексээ батлаад, ингээд индексжээд цаашаа уг нь явж байх ёстой ийм хуультай. Тэгээд энэ батлагдаагүйгээс болоод батлагдахгүй байгаагаас болоод үнийн өсөлтийн энэ магадлалыг манайхаар хийлгэх гээд байдаг ийм зүйл одоо сүүлийн үед түгээмэл болчихжээ.

Тэгэхээр манайх болбол яг энэ Баян-Өлгий энэ эмнэлэгтэй холбоотой асуудлаар бичиг ирсэн. Энэ бичгийн хариуг болбол одоо Барилгын тухай хуульд заасныхаа дагуу шийдвэрлээ. Үнийн өсөлттэй холбоотой асуудлаас болоод цалингийн зөрүү, үнийн өсөлттэй холбоотой ийм магадлал хийлгэчихсэн ийм зүйл юм байна лээ. Энэнээс болоод энэ барилгын асуудал дээр бас гацсан ийм зүйл ажил саатаж байгаа ийм зүйл байгаа юм байна лээ. Тэгээд Барилгын яам руу энэ асуудал бол шилжсэн байж байгаа. Юутай он дамнасан ЭМД-ын сангийн өртэй холбоотой асуултад Наранчимэг дарга хариулах уу.

Д.Батбаяр: 6 номерын микрофон ажлын хэсгийн.

Ц.Наранчимэг: Бейсен гишүүний асуултад хариулъя. ЭМД-ын сангийн өглөгийн үлдэгдэл бол 228.6 тэрбум төгрөг буюу 72.2 хувийг нь улсын эмнэлэг, 64.8 тэрбум төгрөг буюу 20.4 хувийг хувийн хэвшлийн эмнэлэг, 9.7 тэрбум төгрөг буюу 3.1 хувийг Өрхийн эрүүл мэндийн төв, 8.2 тэрбум төгрөг буюу 2.6 хувийг эмийн сан, 5.5 тэрбум төгрөг буюу 1.7 хувийг рашаан сувилалд өгөх ийм одоо өглөг эзэлж байгаа гэдгийг аудитын Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар баталгаажуулсан. ЭМД-ын сангийн орлого, зарлагын өсөлтийг дагаад эм, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсний өглөг бол жил бүр өсөж байгаа. Тухайлбал 2024 онд өмнөх оноос орлого нь одоо 313 тэрбум төгрөг буюу 19.3 хувиар өсөхөд зарлага нь 328...

Д.Батбаяр: 6 номерын микрофон гүйцээж хариулна.

Ц.Наранчимэг: 328 тэрбум төгрөг буюу 20.5 хувиар өглөг нь 98.5 тэрбум төгрөг буюу 45.1 хувиар болбол өссөн байгаа. За ийм учраас бид сая төсвийн тодотголд аудит хийхдээ өмнөх онд ЭМД-ын сангийн эмийн сан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өглөгийн 316.8 тэрбум төгрөгт хүрч, өрийн дарамтад орсон байхад одоо даатгалын сангийн орлогын эх үүсвэр дутагдалтай үед төрөөс үзүүлэх тусламж үйлчилгээний санхүүжилтийг 47.2 тэрбум төгрөгөөр бууруулсан нь бууруулахаар тодотгосон нь иргэдэд үзүүлэх эм, эмнэлгийн тусламж үйлчилгээ бол доголдох эрсдэлтэй байна аа гэж ингэж дүгнэсэн байгаа.

Тэгээд бид одоо энэ нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаараа ЭМД-ын сангийн бүтэц тогтолцоо, үйл ажиллагаа, өр барагдуулах тал дээр бас сайдад нь зөвлөмжийг өгчихсөн байгаа.

Д.Батбаяр: Бейсен гишүүн тодруулж асууна аа.

Б.Бейсен: Тэр Барилгын хөгжлийн төвийн дүгнэлт, Барилгын яамны сайдын дүгнэлт 2 удаа гарсан байна лээ. Тэгэхээр энэ эмнэлгийн асуудал дээр онцгой анхаарахгүй бол болох гээд байна. 2 дугаарт ЭМД-ын сангийн эрсдэлийн сангийн 54 тэрбумыг жилийн эцсээр, дээр нь чөлөөт үзүүлэлтүүдийн 60 хэдэн тэрбум, бас 350 хэдэн тэрбумыг одоо Эрүүл мэндийн сайд шийдэж өгсөн, өр зээлээс салгана гэсэн. Гэтэл энэ дээр аудит хийж үзсэн үү, юунд зарцуулсан байна.

Д.Батбаяр: 6 номерын микрофоны ажлын хэсгийн.

Ц.Наранчимэг: Эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн шууд захирагч эрүүл мэндийн эмнэлгүүдээс өгсүүлээд бүх салбарт бол төрийн аудитын байгууллага төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу санхүүгийн тайлангийн аудитыг бол хийж гүйцэтгэж байгаа. Эрсдэлийн ЭМД-ын сан дээр байгаа эрсдэл төлөвлөсөн мөнгийг бол ЭМД-ын санхүүжилтийн орлого дутагдсанаас өр төлбөрөө барагдуулахад бол төлсөн байгаа. Яг тусгайлан ЭМД-ын сангийн таны ярьсан асуудал дээр бол тусгайлан гүйцэтгэлийн аудитыг бол хийгээгүй ээ.

Д.Батбаяр: Одоо би асуулт асууна аа. Аудитын газраас болон Сангийн яамнаас асууна. Тэгэхээр Сангийн яамнаас асуух асуулт нь бид нар чинь нөгөө өнгөрсөн жил 3 их наядаар нэмээд, улсын төсвөө нэмээд тодотгол хийгээд ингээд явсан гол зорилго нь болохоор 14 мега төсөл гэж ярьсан шүү дээ тийм ээ, тэгээд одоо ингээд дахиад эргүүлээд тодотгол хийгээд ингээд явж байна. Нэг ёсондоо 14 мега төслийг хэрэгжүүлэхийн төлөө бид нар 14 мянга орчим төсвөө нэмээд дараа нь ахиад тодотгол хийж 14 мянган хүний ажлын байртай холбоотой асуудал яригдах гэж байна. Бизнесийн байгууллагуудад өгдөг байсан татаасны асуудлууд яригдах гэж байгаа шүү дээ.

Тэгвэл бидний хамгийн анх төсөв батлахдаа хамгийн түрүүнд гаргаж ирж байсан тэр үндсэн зорилго нь болгож гаргаж ирж байсан 14 мега төслийн маань хэрэгжилт маань 2024 онд ер нь ямархуу байв аа 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт нь бид нар одоо 6 сарын дараа бид нар гүйцэтгэл хэлэлцчихээд явж байгаа. Хүн болгон хариуцлагын асуудлыг ярьж байна. Сая Пүрэвдаваа гишүүн ч бас хэлсэн. Хагас дараагийнх нь жил өнгөрөөд, хагас жил өнгөрчхөөд байхад одоо дөнгөж хэлэлцэж эхэлж байна. Тэгэхээр ийм боломж байгаа юу? Яамны хувьд. Бүх гүйлгээнүүд, бүх зарлагууд яг орсон даруйдаа нэг мэдээллийн сан дээр хадгалагддаг. Төсөв төсөвтэй холбоотой бүх мэдээллүүд мэдээллийн сан дээр хадгалагддаг. Энийг нь яг энэ аудитын байгууллагууд яг бүгд харж байдаг. Хянаж байх ийм бололцоо техник технологийн бололцоо байгаа юу? менежментийн бололцоо байгаа юу гэсэн ийм асуулт байна. Тэгээд энэ тайлангаа гаргахдаа 5 сард биш, 3 сард нь гаргаад явдаг, цаглаврыг нь өөрчлөх ийм бололцоо байгаа юу гэсэн асуулт шүү.

2-т Үндэсний аудитын газраас бас асуух асуулт нь байна. Та бүхэн маань яг энэ аудитын дүгнэлтээ хамгийн түрүүнд тайлан нь бэлэн болсноос хойш яг ингээд бодит байдал дээр нь орох гүйлгээ болгон дээр нь, зарлага болгон дээр нь хянаад, дүгнэлт гаргаад явах ийм бололцоо байгаа юу? Технологийн болон менежментийн бололцоо байгаа юу гэсэн ийм асуултууд байна. За эхлээд Сангийн яам 9 номерын микрофон дээрээс хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Батбаяр гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар. За 14 мега төслийн хувьд бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2 мянга үйл ажиллагааны хөтөлбөрт яг эдийн засгийн бодлогын чиглэлд 14 мега төсөл бол 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр батлагдсан. За эдгээрээс одоо яг гадаад зээл тусламж дээр ашиглалт нь явж байгаа 2 төсөл байгаа. Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС. Бусад үлдсэн төслүүдийн хувьд бол гадаад зээл болон төсөв дээр бол ямар нэгэн байдлаар тусгагдаж санхүүжилт гарсан асуудал бол байхгүй байгаа. Бусад төслүүд илүү төрийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бэлтгэл ажил хангах хүрээнд ингээд явж байгаа.

Таны дараагийн асуулт цахимжилттай холбоотой ялангуяа төсвийн зардал дотор бид нар хөрөнгийн зардлыг бол одоо веб сайт гар утасны аппликэйшн дээр төсвийн хөрөнгө оруулалт гээд цэс болон аппликэйшн гарчихсан байгаа. За энэ бол өөрөө бид нар АХБ-тай хамтраад сүүлийн 3 жил рийл таймаар санхүүжилтийг хүнээс хамааралгүй автомат, бүх мэдээллийг иргэд олон нийт нээлттэй авах байдлаараа нөгөө талдаа бид нар хөрөнгө оруулалтын төслийг яг төслийн яг бүх мөчлөгөөр нь төлөвлөлтөөс нь аваад өмчид бүртгэх хүртэл ийм цахим болгочихсон байгаа. За энэ системийн хувьд бол одоо яг төсвийн хөрөнгө оруулалт гээд орох юм бол бүхий л мэдээллүүд газар зүйн байршил бүх мэдээллээр ил тод нээлттэй байгаа. За үүн дээр бид нар гадаад зээл тусламж өнгөрсөн жил нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтыг бүрэн цахимжуулсан. Гадаад зээл тусламжийн асуудлыг энэ 10 сараас эхлээд ингээд бүрэн энэ цахим системдээ нэгтгэнэ. Тэгэхээр энэ хөрөнгө оруулалтын цахим систем буюу Пимисийн хувьд бол яг Монгол Улсад төсөвтэй холбоотой хөрөнгө оруулалтын бүхий л төслүүдийг төлөвлөлт, санхүүжилтийн үйл ажиллагааг цахимжуулах ийм зорилготой. Ялангуяа 2026 оны төлөвлөлтийг бид нар яг их өгөгдлийг бүх салбараар бүрдүүлээд, төлөвлөлтийг хүнээс хамааралгүйгээр яг их өгөгдөлд суурилан хиймэл оюун ухааныг оруулж ирэх ийм үйл ажиллагааг бол одоо яг хэрэгжүүлээд явж байгаа.

Тэгэхээр та бол яг хөрөнгө оруулалттай холбоотой мэдээллүүд бол энэ нэгдсэн мэдээллийн сан бүрдээд, энэ бүх үйл ажиллагааг хүнээс хамааралтай техник, үйл ажиллагаануудыг бууруулаад ингээд цахимжуулаад явж байгаа, бүрэн нээлттэй байгаа.

Д.Батбаяр: Аудитын байгууллага 6 номерын микрофон дээрээс хариулъя.

Ц.Наранчимэг: Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна аа. Монгол Улсын Ерөнхий аудитор бодлого чиглэлээ гаргаад, Төрийн сангийн гүйлгээг өдөр тутам хянах боломжтой эсэх талаар бид Сангийн яамны удирдлагуудтай уулзсан. Төрийн сангийн өөрийнх нь одоо гүйлгээ гаргаж байгаа нэг гол зорилго бол хяналттай бүх байгууллагын гүйлгээг хяналттай гаргах ийм одоо төрийн сангуудын чиг үүрэг болбол ийм чиг үүрэг байгаа. За бидэнд программын болон шийдлийн хийх асуудлууд байна. За энэ дээр бид нар одоо маш нууц болон нууцтай гүйлгээнүүдээс бусад гүйлгээнүүдийг манайх өнөөдөр төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит хийх пасс системийг хэрэглэж байгаа. Энэ систем мань Төрийн сантай холбох гээд маш олон судалгаа шинжилгээнүүдийн ажлуудыг болбол хийх зайлшгүй шаардлага байна аа гээд 2 удаагийн уулзалтуудыг бол хийсэн байгаа.

Өнөөдрийн яг мөрдөгдөж байгаа...

Д.Батбаяр: 6 номерын микрофоныг нээе гүйцээж хариулъя.

Ц.Наранчимэг: Өнөөдрийн мөрдөгдөж байгаа төсвийн тухай хуулийн 8.9-д заасны дагуу бид нар санхүүгийн тайланг баталгаажуулах аудитыг хийж байгаа. Энэ аудит маань хийх өөрөө цаглаварт хугацаануудыг заагаад өгчихсөн. За тайланг бол он гарсны дараа төсвийн шууд 2 сарын 25-нд, төрийн өмчид 3 сарын 15-нд төвлөрүүлэн 3 сарын 25-нд гээд ингээд цаглаварт хугацаануудыг зааж өгөөд, аудитын байгууллагын дүгнэлт гаргах бас хугацааг заагаад өгчихсөн байгаа. Одоо хуульд аудитын байгууллага яг өдөр тутмын гүйлгээг гаргаад одоо тайлан гаргана аа гэсэн ийм хуулийн заалт байхгүй. Нэгэнт энэ аудитын маань гол зорилго санхүүгийн 4 тайлангаа баталгаажуулах ийм одоо зорилготой аудит стандарт нь ч гэсэн өөрөө тийм байгаа учраас өдөр тутмын гүйлгээг хянаад, тайлан ирүүлэх болбол боломжгүй байх гэж ингэж бодож байна.

Д.Батбаяр: Би тодруулаад асуучихъя. Нөгөө Сангийн яамнаас асуугаад байгаа нь мэдээж бүх мэдээллүүд нь байгаа боловч яг энэ яг хамгийн эцсийн байдлаар нь шууд аудитын дүгнэлт хийгээд энэ дээр нь ахиад хяналт хийгээд хариуцлага тооцчих боломжтой юу гэдэг л асуултыг асуугаад байгаа байхгүй юу. Мэдээж та хэд бүх мэдээллээ оруулчих. За тэгээд асуудал босож ирээд, хяналт тавиад, аудит хийгдээд эхэлсний дараа энэ яг эцсийн байдлаар биш юмаа гэсэн иймэрхүү байдал бий болох вий гэж асууж байгаа байхгүй юу 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт нь ахиад тодруулж асуухад яг энэ нөгөө гүйцэтгэлтэй холбоотой, гүйцэтгэл нь ихэвчлэн тоон дээр суурилсан байгаад байна аа. Зарим тоонууд нь суурь энэ тоонууд нь бүгдээрээ зөрсөн. Нэг болбол тоогоор асуудаг, нэг болбол хувиар шалгадаг. Ингээд энэ гүйцэтгэлийн параметрууд нь өөрөө янз бүр байгаад байгаа. Энийг нэг хэлбэрт оруулах боломж байдаг юм уу? Бид нарыг зөвхөн мөнгөн дүнгээр гүйцэтгэл ярьдаг болчихоод байгаа юм. Тэгээд бодит байдал дээрээ яг энэ хөгжлийнхөө хөтөлбөртэйгөө яаж уялддаг юм бэ? Энийг уялдуулаад илүү бодитойгоор хэмждэг, хянадаг болох ийм ямар өөрчлөлтийг хийх боломж байна аа гэсэн ийм асуултыг ахиад нэмээд асуучихъя. Ажлын хэсгийн 9 номерын микрофоныг нээе.

М.Санжаадорж: Сангийн яам Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж байна аа. Гишүүний асуултад хариулъя аа. Тийм тэгэхлээр гүйцэтгэл дээр болбол яах вэ бидний одоо яг өмнө нь явж ирсэн энэ практик маань юу вэ гэхлээр болбол зарлагын эдийн засгийн ангилал дээр хийсэн гүйцэтгэл дүгнэлт. Энэ дээрээсээ мөн хариуцлагын асуудал ярьж байгаа ийм зүйл яваад байгаа юм. Бид болбол яах вэ зүгээр дунд хугацаандаа бол юуг өөрчлөх гээд байна гэхлээр 1-ээс илүү жилийн төсөвлөлт гэдэг зүйлийг яриад байгаа юм. Өөрөөр хэлбэл нэг жилийн төсөвлөлтөө бид нар нэг бодитой хийгээд болж өгвөл нэг 2 жилийн төсөвлөлт хийх асуудал. Энэний хамгийн гол зорилго нь юу вэ гэхлээр үр дүнтэйгээ төсвөө уях асуудал байгаад байгаа юм. Энэ төсвөөрөө ямар зүйл хийх юм бэ, ямар одоо кірі аі-ууд нь ямар байдлаар өөрчлөгдөх юм бэ гэдэг энэ зүйлүүдийг л бид нар харах гээд байгаа юм.

Цаашдаа болбол бид нар Үндэсний аудитын газартай болон бусад салбар яамдуудтайгаа болбол ямар байдлаар ярьж байгаа вэ гэхлээр.

Д.Батбаяр: 9 номерын микрофон дээр Санжаадорж дарга гүйцээж хариулъя.

М.Санжаадорж: Тийм үр дүнд чиглэсэн байдлаар төсвийн төсөвлөлтөө хийгээд сурчих юм бол мөнгөн дүнгээ зарцуулсан байж болно. 100 төгрөг зарцуулахыг яг зориулалтынх нь дагуу 100 төгрөг зарцуулсан байж болно. Үр дүндээ хүрсэн байж болно. Гэхдээ энэ мөнгөөр илүү үр дүнд хүрэх байсан уу, үгүй юу гэдэг дээр Үндэсний аудитын байгууллагаас жишээ нь менежментийн хувьд болбол зөв буруу хийсэн дээр бас одоо санал дүгнэлт өгөх. Хэрэвзээ 100 төгрөгөө зарцуулчихаад зорьсон үр дүн маань хүрээгүй байх юм бол энэ дээр ямар алдаа дутагдал гарсан бэ, цаашид бид нар яах ёстой вэ гэдэг дээрээ ярих. Мөн энэ үр дүнд суурилсан төсөөлөлт маань өөрөө жилийн дундуур болбол хэрвээ тодотгол орвол бид нар үр дүнгээ яаж өөрчилж байх вэ, өөрчлөхгүй байх вэ. За тодотгол орсон боловчиг жилийн эцэст үр дүнгээ бас яаж мөрдөж байх вэ гэдэг ийм зүйл рүү бол явахгүй үзээд байгаа юм.

Яг Сангийн яаман дээр хийгдэж байгаа ажлын хувьд бид Үндэсний аудитын байгууллагатай хамтраад эхний ээлжид болбол төрийн сангийн программ дээр санхүүжилтийн гүйцэтгэлээ бол үр дүнтэй нь уясан байдлаар программ хийх гээд үзэж байгаа.

Д.Батбаяр: Санжаадорж дарга гүйцээж хариулъя. 9 номерын микрофоныг нээе.

М.Санжаадорж: Тийм, тэгээд Төрийн сан дээрээ бол эхний ээлжид ямар ч байсан гүйцэтгэлээ бид нар энэ үр дүнтэй нь уях энэ программыг нэвтрүүлэх гээд үзээд байгаа. 2 дахь асуудал бол юу орж ирэх вэ гэхлээр төлөвлөлт тал дээрээ бид нар одоо хаана байгаагаа 1 дүгээрт мэдчихээд, хаашаа өргөх вэ гэдгээ мэдчих юм болбол энэндээ таарсан бас мөнгөн хөрөнгийг бас зөв төлөвлөх асуудал болбол орж ирэх гээд байгаа юм. Хэрвээ тэгсэн тохиолдолд бол одоо энэ хэмнэлтийн асуудал байх юм уу эсвэл төсөв давж зарцуулах байдаг юм уу, ийм асуудлууд бол гарч ирэхгүй болох л уул нь яг онолын хувьд бол тийм байгаад байгаа юм.

Төсвийн тухай хуулийн хувьд болбол энэ боломжууд маань бол хууль эрх зүйн хувьд болбол байж байгаа. Бид бол энийг цаашаа бас хэрэгжүүлээд явахыг хүсэж байгаа. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө бол илүү хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ рүү чиглэсэн байдаг бол төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт болбол илүү Кэй Пи Ай буюу шалгуур үзүүлэлт рүүгээ чиглэсэн ийм үзүүлэлт байгаад байгаа юм. Цаашдаа энийгээ л анхаарах ёстой гэж бодож байна. Баярлалаа.

Д.Батбаяр: Юу билээ? Одоо би ч нэг минутаар ахиад тодруулах эрхтэй тиймээ. Тэгэхээр би нөгөө Дэлгэржаргал даргаас ахиад нэг юм асуучихъя. Саяхан би энэ Баруунбүрэн сумын нутаг дээр очиж бүтээн байгуулалтын ажилтай танилцсан. Энэ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа энэ Орхон гол дээгүүр баригдаж байгаа гүүрний асуудал. Тэгээд би чинь 6 сарын 10 хавьцаа очсон. Тэгэхэд тэнчээ хэдэн машин техник хэрэгсэл очсон байсан боловч яг гүүрний барилга угсралтын ажил бол эхлээгүй байсан. Нэг жилийн өмнөх яг тэр байдалтай байсан байхгүй юу.

Тэгэхээр энэ санхүүжилт нь яаж хийгдэж байна? Энэ хэзээ эхлэх ёстой байсан ажил, гэрээ хийгдсэн үү, ямар байгууллагууд гэрээ хийсэн бэ? Энэ хэзээнээс эхлэх ёстой байсан бэ? энэ дээр хэн хяналт авах вэ гэсэн ийм асуулт байна. Ажлын хэсгийн 9 номерын микрофоныг нээе.

Ж.Дэлгэржаргал: Батбаяр гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Тэгэхээр хөрөнгө оруулалтын ажлууд бол яг гүйцэтгэлд үндэслэж санхүүжилтийг олгодог. Яг Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолоор батлагдсан журам байдаг. 2023 оны 278 гээд. Энэ журам дээр ялангуяа яг энэ санхүүжилтийг бол тоног төхөөрөмж бол яг хүлээж авсны дараа барилга угсралтын ажил бол яг хийсэн ажилд нь үндэслэж олгодог. Тэгэхээр энэ гүүрний хувьд бол яг захиалагч илүү гэрээ байгуулсан гүйцэтгэгчтэй хийсэн ажлын дараа л бид нар санхүүжилтээ, урьдчилж бол санхүүжилт олгохгүй. Тэгэхээр таны асууж байгаа гүүр нөгөө Орхонтуулын гүүр байгаа байх тиймээ. Орхонтуулын гүүрний хувьд бол өмнө нь батлагдаад өмнөх батлагдсан санхүүжилт нь тэр гүүрний яг ингээд талд нь хүрээд ингээд дуусаад яг тэр ажлаар нь ингээд комисс хүлээгээд авчихсан байсан. За өнгөрсөн жил бид нар яг энэ дээр дахиж магадлал ороод аудитын дүгнэлт хянагдаад тэр дүнгээр нь 6.5-ийг тавьчихсан байгаа. Тэгэхээр одоогоор бол энэ ажил дээр энэ жилийн хувьд бол санхүүжилт гараагүй байгаа. Тэгэхээр...

Д.Батбаяр: Ажлын хэсгийн 9 номерын микрофоныг нээе. Дэлгэржаргал дарга гүйцээж хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Тэр ажлаа хийгээд яг гүйцэтгэл гарсны дараа л бид нар санхүүжилтийг олгоно. За энэ жил бол яг энийг бүрэн одоо гүйцээж дуусгахаар 6.5 бол батлагдчихсан. Сая тодотголоор бол ямар нэгэн өөрчлөлт ороогүй байгаа. Хяналтыг бол Зам, тээврийн хөгжлийн төв захиалагч хяналтыг тавьж байгаа. Зам тээврийн яам өөрөө захиалагчийн хяналтыг. Өмнө тэр хүлээж авсан нь бол Сэлэнгэ аймаг өөрөө байсан.

Д.Батбаяр: Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? За би ганцаараа юм шиг байна.

Тэгэхээр төсвийн гүйцэтгэлтэй холбоотойгоор маш их асуудлууд гарч ирж байна. Хэдхэн хоногийн өмнө 7 хоногийн өмнө бид нар өнгөрсөн жилийн төсвийг хэлэлцэж байх үед хамгийн их хүмүүсийн олон нийтийн анхаарлыг татаж байсан. Энэ бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал хэт өсөж байна аа гэсэн энэ асуудлыг хөндөж байсан 38 хувь буюу 2023 онд 1.1 их наяд төгрөгийг бусдаар ажил гүйцэтгүүлэхэд зарцуулж байсан болбол 2024 онд 1.49 буюу 38 хувиар өссөн. Тэгэхээр энийг яг энэ эдийн засгийн ангиллаар нь гаргаад яг энэ зөвхөн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээтэй холбоотой бусдаар буюу төрийн бус байгууллагууд хувийн хэвшлээр хийлгэж байгаа энэ ажлуудыг яг энэ ангилалд нь багтаадаг байдлаар ингэж шинээр нь ингэж илүү бодитой, илүү үр ашигтайгаар нь ингэж оруулдаг, ангилдаг болмоор байгаад байгаа юмаа гэдэг энэ саналыг би бүүр онцолж хэлмээр байна.

2 дугаарт нь хариуцлагатай холбоотой асуудал. Аудитын байгууллага мэдээж тодорхой саналуудыг бас хэлсэн. Зарлагын хяналтын дэд хороотой хамтарч ажиллаж байгаа. Тогтоолын төслийг санал болгож байгаа. Гэхдээ энэ тогтоолын төслийг бид нар өдийд хэлэлцээд, ажлын хэсэг гаргаад, шинэ санал аваад Улсын Их Хурлын чуулганаар оруулаад, гишүүдийн саналыг аваад, тогтоолын төсөл болгоод Засгийн газарт үүрэг болгож, чиглэл болгож өгөх болбол цаг хугацааны хувьд боломжгүй болчихоод байгаа юм. Энэ юуг харуулаад байна аа гэхээр цаглавар дээр ерөөсөө асуудал байгаад байна. Бид нар 6 сарын 20 хүргэж аудитын байгууллагын тайлангаа аваад, 7 сарын 1-ндээ багтааж тайлангаа хэлэлцээд,

гүйцэтгэлээ баталдаг байгаа нь ерөөсөө цаг хугацааны хувьд боломжгүй байгаад байгаа юм.

Тийм ч учраас энэ тайлан хүргүүлдэг Засгийн газрын болон төсвийн ерөнхийлөн захирагч нарын үйл ажиллагааны тайланг хүргүүлдэг энэ механизмыг бид нар илүү хурдан болгомоор байгаа юм. Сүүлийн 30 жилийн турш бид нар ярьж байгаа. Бид нар үйл ажиллагаагаа илүү технологийн шинэчлэлийг ашигладаг цаг тухай бүрд нь тайлагнадаг, энэ мэдээллийн технологийг илүү ашигладаг болно оо гээд. Одоо бид нарын эргээд ингээд харах юм болбол энэ санхүүгийн тайлан дээр ч гэсэн байж байгаа. Мэдээллийн технологийг ашигласан нь зардлууд гээд. Шинжлэх ухааны технологийг шинээр хүлээж авч байгаа зардлууд гээд байнга гараад явж байгаа. Тэгвэл үр дүн нь гарахгүй байгаад байгаа юм. Рийл тайм буюу яг зарлагадсан даруйд нь тэр зарлал нь гарч ирдэг, тэрийг нь хянаж чаддаг тэрэнд нь хүн болгон хүрч чаддаг, гишүүн болгон орж харж чаддаг ийм болох хэрэгтэй байгаад байгаа юм.

Өнөөдөр төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхэд, тодотголыг хэлэлцэхэд бид нар үндсэндээ нэг ширхэг эксел файл дээр л нэг дата дээр л бид нар суурилж шинжилгээ хийж явж байгаа шүү дээ. Тэгээд энэ төсөвтэй холбоотой, зарлагатай холбоотой мэдээллүүдийг авахад маш төвөгтэй болчихоод байгаа юм. Тэгэхээр мэдээлэлд ойрхон байх, мэдээллийг илүү хялбар болгох тал дээр нь бас анхаарч ажилламаар байна аа гэсэн ийм үндсэн 2 саналыг хэлье.

Гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанаар хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх талаар Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Дэд хорооны дарга Батбаяр уншиж танилцуулна аа.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Ажлын хэсгийнхэн болон гишүүдэд талархаж байна аа.

12:16

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ